

## **ОЮУ ТОЛГОЙ УУРХАЙН ТӨСӨЛ**

**БОНХЗ-ийн 2017 оны 5-р  
сард уурхайд ажилласан  
тайлан**



**Баримт бичгийн дугаар. 13-391-Н10 Хувилбар 0 –2017 оны 8-р сар**

**ОЮУ ТОЛГОЙ УУРХАЙН ТӨСӨЛ**

**БОНХЗ-ийн 2017 оны 5-р сард уурхайд ажилласан тайлан**

<b>Тайлангийн хувилбар</b>	<b>Гарсан огноо</b>
I төсөл	2017 оны 6-р сарын 28
II төсөл	2017 оны 7-р сарын 31
III төсөл, эцэслэсэн хувилбар	2017 оны 8-р сарын 18

<b>Хэнд зориулсан:</b>	<b>Давуу эрхтэй зээлдүүлэгчдийн групп</b>

<b>Багийн гишүүд:</b>	
Жиованни Ди Франчи	Төслийн менежер, багийн ахлагч – Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны мэргэжилтэн
Роберт Сноу	Ахлах хянагч – Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, уул уурхайн мэргэжилтэн
Дана Стренг	Байгаль орчин/Гидрологийн мэргэжилтэн
Эми Сэкстон, Анжела Рийман	Нийгмийн харилцаа/Орон нутгийн харилцааны асуудал хариуцсан мэргэжилтнүүд
Ровена Смац, Жоанна Трийвик	Биологийн олон янз байдлын мэргэжилтэн

<p><b>RINA Consulting S.p.A.</b>            Società soggetta a direzione e coordinamento amministrativo e finanziario del socio unico RINA S.p.A.            Via San Nazaro, 19 - 16145 Genova            Tel. +39 010 3628148 - Fax +39 010 3621078 - www.rinaconsulting.org - rinaconsulting@rinaconsulting.org            C.F. / P. IVA / R.I. Genova N. 03476550102 - Cap. Soc. € 520.000,00 i.v.</p>
<p>All rights, including translation, reserved. No part of this document may be disclosed to any third party, for purposes other than the original, without written consent of RINA Consulting S.p.A.</p>

## ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛАЛ	2
ЕРӨНХИЙ ХУРААНГУЙ	5
1 УДИРТГАЛ	20
2 ТӨСЛИЙН ТОЙМ	22
2.1 БАРИЛГА, АШИГЛАЛТЫН ЯВЦ	22
2.2 ТАЙЛАНГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	23
3 ЗӨРЧЛИЙН ХҮСНЭГТ	24

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛАЛ

<b>АЯХХМТ</b>	Агаарт ялгарах хийн хаягдлын менежментийн төлөвлөгөө
<b>АЧХШТ</b>	Агаарын чанарын хяналт шинжилгээний төлөвлөгөө
<b>БОЯБУАТ</b>	Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө
<b>БОЯБҮМХ</b>	Биологийн олон янз байдлын үнэлгээ, хяналт шинжилгээний хөтөлбөр
<b>БОЯБМТ</b>	Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөө
<b>БТБМТ</b>	Бизнесийн тогтвортой байдлын менежментийн төлөвлөгөө
<b>ХДХЗО</b>	Хууль дүрмийн хэрэгжилтийн зөвлөх Омбудсман
<b>НЭХТМ</b>	Ноцтой эрсдэлийн хяналтын талбайн магадлагаа
<b>НЭХМ</b>	Ноцтой эрсдэлийн хяналтын магадлагаа
<b>ТИГ</b>	Төвлөрсөн инженерингийн групп
<b>ХХБХШС</b>	Хүлэмжийн хийн байнгын хяналт шинжилгээний систем
<b>ГЕЗ</b>	Гүйцэтгэх ерөнхий захирал
<b>СӨ</b>	Соёлын өв
<b>СӨМТ</b>	Соёлын өвийн менежментийн Төлөвлөгөө
<b>СӨМС</b>	Соёлын өвийн менежментийн систем
<b>ДТС</b>	Дулааны Төв Станц Орон Нутгийн Эрүүл Мэнд, Аюулгүй ажиллагаа, Аюулгүй Байдлын
<b>ОНЭМАААБМТ</b>	Менежментийн Төлөвлөгөө
<b>ИХТ</b>	Иргэдийн хөгжлийн төв
<b>ТШХО</b>	Том ширхэгт хүдрийн овоолго
<b>НЭМ</b>	Ноцтой эрсдэлийн менежмент
<b>ОНТО</b>	Орон нутаг, талуудын оролцоо
<b>ОНТОХС</b>	Орон Нутаг, Талуудын Оролцоог Хянах Систем
<b>ОНХНХ</b>	Орон Нутгийн Харилцаа, Нийгмийн Хариуцлага
<b>ОНХНХМС</b>	Орон Нутгийн Харилцаа, Нийгмийн Хариуцлагын Менежментийн Систем
<b>ХДС</b>	Хөгжлийг дэмжих сан
<b>ЕСБХБ</b>	Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк
<b>ЦДЧ</b>	Цахилгаан дамжуулах чанар
<b>ЭЗА</b>	Экспортын Зээлийн Агентлагууд
<b>КЭХА</b>	Канадын Экспортын Хөгжлийн агентлаг
<b>ЭСДК</b>	Экспортын Санхүү, Даатгалын Корпораци
<b>МТ</b>	Малчдын төлөөлөл
<b>ОБЕББААХТ</b>	Онцгой байдлын үеийн бэлэн байдал, авах арга хэмжээний төлөвлөгөө
<b>ХХ</b>	Хөдөлмөрийн харилцаа
<b>ОБТ</b>	Онцгой байдлын төлөвлөгөө
<b>ОББ</b>	Онцгой байдлын баг
<b>БОНУАТ</b>	Байгаль Орчин, Нийгмийн Үйл Ажиллагааны Төлөвлөгөө
<b>БОННУ</b>	Байгаль Орчин, Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээ
<b>БОНМТ</b>	Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө
<b>ЭҮҮХШТ</b>	Экосистемийн үйлчилгээний үнэлгээ, хяналт шинжилгээний төлөвлөгөө
<b>ФФИ</b>	Фауна энд флора интернэшнл
<b>ГХ</b>	Гүний хоолой
<b>ХХЯ</b>	Хүлэмжийн хийн ялгаралт
<b>СОУТТ</b>	Салбарын олон улсын тэргүүн туршлага
<b>ХН</b>	Хүний нөөц
<b>ЭМААБО</b>	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин
<b>ЭМААБОМС</b>	Эрүүл Мэнд, Аюулгүй Ажиллагаа, Байгаль Орчны Менежментийн Систем
<b>ЭМААБООН</b>	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, орон нутаг

<b>БОНХЗ</b>	Байгаль орчин, нийгмийн хөндлөнгийн зөвлөх
<b>ХШЗ</b>	Хөндлөнгийн шинжээчдийн зөвлөл
<b>ОУСК</b>	Олон Улсын Санхүүгийн Корпораци
<b>ОУСБ</b>	Олон Улсын Санхүүгийн Байгууллага
<b>ХАШИХМТ</b>	Хүн амын шилжин ирэх хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө
<b>ОУШХБ</b>	Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллага
<b>ДБХТХТ</b>	Дахин боловсруулах хаягдал түр хадгалах төв
<b>ККБ</b>	Клохн Криппен Бергер
<b>ГҮҮ</b>	Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд Зээлдүүлэгчдийн шаардсан Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө
<b>ЗБОЯБУАТ</b>	
<b>ГХХНСМТ</b>	Газар хөндөлтийн хяналт ба нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө
<b>ГХЗ</b>	Газар хөндөх зөвшөөрөл
<b>АХМТ</b>	Ажиллах хүчний менежментийн төлөвлөгөө
<b>ХЧАОГ</b>	Хөдөлмөрийн чадвар алдсан осол гэмтэл
<b>ХЧАОГДХ</b>	ХЧАОГ-ийн давтамжийн хэмжээ
<b>ГАМТ</b>	Газар Ашиглалтын Менежментийн Төлөвлөгөө
<b>ШУА</b>	Шинжлэх ухааны академи
<b>ОТШБ</b>	Олон талт шинжээчдийн баг
<b>БОНХЯ</b>	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
<b>ОТБГА</b>	Олон талын баталгаа гаргагч агентлаг
<b>УЛТ</b>	Уурхайн лицензийн талбай
<b>ӨМ</b>	Өөрчлөлтийн менежмент
<b>ШУТИС</b>	Шинжлэх ухаан, технологийн их сургууль
<b>ЭХМТ</b>	Эрдэс хаягдлын менежментийн төлөвлөгөө
<b>ХҮЧ-гүй</b>	Хүчил Үүсгэх Чадваргүй
<b>ӨМ</b>	Өөрчлөлтийн мэдэгдэл
<b>НУУТ</b>	Нутгийн ургамал үржүүлгийн төв
<b>ЦЭН</b>	Цэвэр эерэг нөлөөлөл
<b>ДХМТ</b>	Дүйцүүлэн хамгаалах менежментийн төлөвлөгөө
<b>ОТ</b>	Оюу толгой
<b>ОТ-ГС</b>	Оюу толгой – Гашуун Сухайт
<b>ОТ-ХБ</b>	Оюу толгой – Ханбогд
<b>ХҮЧ-тай</b>	Хүчил Үүсгэх Чадвартай
<b>БОХОХШ</b>	Байгаль орчны хамтын оролцоотой хяналт шинжилгээ
<b>БАСМТ</b>	Бэлчээр, амьжиргаа сайжруулах менежментийн төлөвлөгөө
<b>БМТ</b>	Бэлчээрийн менежментийн төлөвлөгөө
<b>ГШ</b>	Гүйцэтгэлийн Шаардлага
<b>ГС</b>	Гүйцэтгэлийн Стандарт
<b>НШУАТ</b>	Нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө
<b>РТ</b>	Рио Тинто
<b>РТБШ</b>	Рио Тинто Бизнес Шийдэл
<b>СЧБ</b>	Стандарт чартеред банк
<b>ОТХАТ</b>	Оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө
<b>АХХ</b>	Ажлын хамрах хүрээ
<b>ТХГ</b>	Тусгай хамгаалалттай газар
<b>УХБНХ</b>	Ууссан хатуу бодисын нийт хэмжээ
<b>ТМТ</b>	Тээврийн менежментийн төлөвлөгөө
<b>ГТЗ</b>	Гурван талт зөвлөл

<b>т/хон</b>	тонн/хоног
<b>ХХБ</b>	Хаягдал хадгалах байгууламж
<b>ГУ</b>	Гүний уурхай
<b>АНУ ЭИБ</b>	АНУ-ын экспорт импортын банк
<b>ЗАХН</b>	Зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг
<b>ХХМТ</b>	Хог хаягдлын менежментийн төв
<b>УХШТ</b>	Усны хяналт шинжилгээний төлөвлөгөө
<b>ХЧО</b>	Хаягдал чулуулгийн овоолго
<b>УНМТ</b>	Усны нөөцийн менежментийн төлөвлөгөө

## ЕРӨНХИЙ ХУРААНГУЙ

Оюу толгой төсөл нь (цаашид “Төсөл” буюу “ОТ төсөл” гэнэ) Өмнөговь аймгийн Ханбогд суманд<sup>1</sup> байрлах, дэлхийд томоохонд тооцогдох зэс-алтны уурхайн төсөл юм. Уг төсөл нь Монгол улсын нийслэл Улаанбаатар хотоос өмнө зүгт ойролцоогоор 600 км, Монгол-Хятадын хилээс хойш 80 км-т, Өмнийн говийн бүс нутагт байрладаг. Тус орд нь зэс, алт, мөнгө болон бага хэмжээний молибден бүхий хэд хэдэн бүлэг ордоос бүрдэнэ. Уг төслийг Монгол улсын засгийн газрын бүрэн эзэмшлийн Эрдэнэс оюу толгой (34 хувь) компани, Түркуойз хилл ресурс (66 хувь) компаниудын хувь нийлүүлсэн аж ахуйн нэгж болох “Оюу толгой” ХХК хэрэгжүүлж байна. Рио Тинто (РТ) нь Түркуойз хилл ресурс компанийн гол хувьцаа эзэмшигч бөгөөд 2010 оноос хойш бүх хувьцаа эзэмшигчдийг төлөөлөн уг төслийг албан ёсоор удирдаж байна. Уг төсөл нь одоо үйл ажиллагаа явуулж байгаа зэс-алтны ил уурхай, түүнээс гарсан хүдрийг боловсруулах үйл ажиллагаа, зэс-алтны гүний уурхайн бүтээн байгуулалт, барилга угсралт, ашиглалтын үйл ажиллагаанаас бүрдэнэ.

2013 оны 9 дүгээр сараас эхлэн Итали улсын Генуя хотод байрлах Д'Апполониа компани (2017 оны 6 дугаар сарын 5-наас эхлэн АрАЙЭНЭЙ Консалтинг болсон)<sup>2</sup> Оюу толгой төслийг санхүүжүүлж буй давуу эрхтэй Зээлдүүлэгчдийн<sup>3</sup> группийг төлөөлөх Байгаль орчин, нийгмийн хөндлөнгийн зөвлөх (БОНХЗ)-өөр томилогдсон билээ.

БОНХЗ нь баримт бичигт тулгуурласан аудит хийхээс гадна Төслийн талбайд хуваарийн дагуу очиж шалгалт хийн, уг Төсөл хүлээсэн үүрэг амлалтаа Зээлдүүлэгчдийн холбогдох стандарт шаардлагын дагуу биелүүлж буй эсэхэд хяналт тавих үндсэн үүрэгтэй. Тодруулбал:

- Үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөө (YAMT), Байгаль орчны үйл ажиллагааны төлөвлөгөө (BOYAT)-нд тусгасан амлалт үүргийн хэрэгжилтийг үнэлэх;
- YAMT, BOYAT-ний амлалт үүрэгтэй холбоотой аливаа зөрчил мөн/эсвэл дутагдал илрүүлэх, илэрсэн тохиолдолд Салбарын олон улсын тэргүүн туршлага (СОУТТ)<sup>4</sup>-д үндэслэн зөрчил, дутагдал арилгах санал зөвлөмж өгөх;
- БОНХЗ-ийн 2016 оны 8-р сард уурхайд ажилласан тайланд<sup>5</sup> дурдсан тодорхой асуудал/зөрчлийг тодорхойлж, түүний мөрөөр арга хэмжээ авч, зөрчил, ажиглагдсан зүйлсийг хаах үүрэгтэй.

Энэ тайланд БОНХЗ 2017 оны 5 дугаар сарын 22-26-ны өдрүүдэд уурхайд ажиллахдаа хийсэн дүгнэлтийг тусгав. Уурхайд ажилласан гол зорилго нь ОТ-н үйл ажиллагаанд, ялангуяа эрүүл мэнд, аюулгүй

<sup>1</sup> Сум нь Монгол улсын хоёрдахь шатны засаг захиргааны нэгж юм. Одоогийн байдлаар Монгол улсад 300 орчим сум байна.

<sup>2</sup> 6-р сарын 5-нд Д'Апполониа компани болон АрАЙЭНЭЙ группийн бусад инженерингийн зөвлөх компаниуд нэгдэж, АрАЙЭНЭЙ Консалтинг компанийг үүсгэсэн. Тиймээс, АрАЙЭНЭЙ Консалтинг нь Д'Апполониа (D'Appolonia), Центро Свилуддо Материали (Centro Sviluppo Materiali), Эпиф ИАрЭй Технологи (Edif ERA Technology), Жи.И.Ти (G.E.T), Логмарин Эдвайзорс (Logmarin Advisors), ӨүЭсТи Энэржи (OST Energy), Поарис (Polaris), СиЭс Сэмбэнэли Консалтинг (SC Sembenelli Consulting), Ситек (Seatech) зэрэг олон улсад нэр хүндтэй хэд хэдэн компаниудыг нэгтгэсэн инженерингийн мэргэжлийн зөвлөх үйлчилгээний арвин их өв туршлагыг нэг дор цуглуулсан байгууллага юм.

<sup>3</sup> Давуу эрхтэй Зээлдүүлэгчдийн группэд Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК), Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ), Канадын экспортын хөгжлийн агентлаг (КЭХА), АНУ-ын Экспорт, импортын банк (АНУ ЭИБ), Экспортын санхүү, даатгалын корпорац (ЭСДК), Олон талын баталгаа гаргагч агентлаг (ОТБГА), Стандарт чартеред банк (СЧБ), БиЭнПи Парибас байгууллага орно.

<sup>4</sup> 2007 оны 4-р сард ОУСК-аас гаргасан БОЭМАА-ны удирдамжид Салбарын олон улсын тэргүүн туршлага (СОУТТ) гэдгийг “олон улсад ижил төстэй нөхцөлд, ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлж буй, туршлага, үр чадвар эзэмшсэн мэргэжилтнүүдэд зүй ёсоор тавигдах мэргэжлийн үр чадвар, хичээл зүтгэл, онч ухаан, алсыг харах чадвар...” гэж тодорхойлжээ.

<sup>5</sup> 2016 оны 10-р сарын “Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн хяналт шинжилгээний тайлан – 2016 оны 8-р сард уурхайд хийсэн аудитын тайлан”, баримт бичгийн дугаар 13-391-Н9, Д'Апполониа

ажиллагаа, байгаль орчин, нийгмийн чиглэлийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт үнэлгээ хийх, төслийн үйл ажиллагааны/ашиглалтын үе шатан дахь байгаль орчин, нийгмийн үүрэг амлалтын биелэлтэд хяналт тавих, төслийн нөлөөллийг бууруулах арга хэмжээг зохих шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж буй эсэхийг тодорхойлоход оршино.

Энэхүү аудитын тайланд Үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөө (ҮАМТ), Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ), Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө (БОНУАТ), бусад холбогдох баримт бичигт тусгасан Төслийн үүрэг амлалттай холбоотой илэрсэн зөрчлийг (3-р хэсэг дэх Төслийн үйл ажиллагаанд илэрсэн зөрчлийн хураангуйлсан хүснэгтийг үзэх) арилгах талаар ямар арга хэмжээ авч байгаа тухай мэдээллийг тусгав.

Уурхайд хийсэн энэ удаагийн аудитын тайланд онцолсон гол зүйлсийг дор товч хураангуйлав.

***Байгаль орчин, нийгмийн менежментийн тогтолцоо***

Байгаль орчин, нийгмийн менежментийн тогтолцоо нь төслийг удирдан явуулах, Төслийн стандартууд, Монгол Улсын хууль, дүрэм журам, тусгай зөвшөөрлийн нөхцөл, 2009 оны 10-р сарын 6-нд байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээ, ОУСК, ЕСБХБ-ны байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, нийгмийн бодлого, стандарт шаардлагуудыг хангах цогц тогтолцоо юм. Уг менежментийн систем болон холбогдох Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ) нь тасралтгүй шинэчлэн сайжруулахад чиглэсэн төлөвлөх, үйл ажиллагаа явуулах, тайлагнах, хяналт тавих зэрэг үе шатуудаас бүрдэнэ. Тусгай/Тодорхой үйл ажиллагааны төлөвлөгөөнд төслийн үүрэг амлалт, гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд, хяналт шинжилгээ хийх параметр үзүүлэлтүүд, хэрэгжилтийг хангах холбогдох баримт бичгүүдийг тодорхойлдог. Үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийг 2015, 2016 онуудад шинэчилсэн, харин БОНМТ-г 2017 оны сүүлээр шинэчлэх юм. Уг тогтолцооны бас нэг хэсэг нь Өөрчлөлтийн менежментийг хэрэгжүүлэх процесс бөгөөд энэ тайлангийн холбогдох хэсгүүдэд дурдсан төслийн төлөвлөгөө, үүрэг амлалтад засвар өөрчлөлт оруулах явцыг уг процессын дагуу удирдан явуулдаг. Зээлдүүлэгчдийн оруулсан өөрчлөлтийн ихэнхийг нь хүлээн авсан бөгөөд хараахан зөвшөөрч, хүлээн аваагүй байгаа асуудлуудын тал дээр шийдэлт хүрэхийн тулд хянан үзэж, хяналт шинжилгээ хийж байна.

***Цэвэр, бохир усны менежмент***

БОННУ-нд тусгасны дагуу Ундай голын голдирылыг бүхэлд нь өөрчлөх боломжгүй болсон тул ОТ компани Ундай голыг хамгаалах, хэсэгчлэн тохируулга хийх төсөл хэрэгжүүлсэн. Газар ашиглах зөвшөөрөл олгох асуудал урт хугацаагаар хойшилсны улмаас Уурхайн лицензийн талбайн (УЛТ) хашаанаас гадна хийгдэх Ундай голын голдирылыг өөрчлөх төслийн барилгын ажлууд хийгдээгүй. Ундай голыг хамгаалах, хэсэгчлэн тохируулга хийх төслийн системийн ажиллагааг үнэлэх зорилгоор бэлэн байгаа гидрогеологийн мэдээлэлд үндэслэн 2014 оны 11-р сард усны нарийвчилсан үнэлгээ хийсэн. Усны нарийвчилсан үнэлгээгээр одоо ашиглаж буй системээс үүдэн гүний усанд их хэмжээний нөлөөлөл үзүүлэх эрсдэл илрээгүй. 2015-005 дугаартай Өөрчлөлт оруулах мэдэгдэлд Ундай голыг хамгаалах, хэсэгчлэн тохируулга хийх төсөл нь гүний усны хэвийн урсацад нөлөөлөхгүй бөгөөд БОННУ-нд тусгасны дагуу Ундай голын голдирылыг өөрчлөх анхны зорилгод нийцсэн бодитой шийдэл болж чадахыг хүлээн зөвшөөрсөн.

2014 оны 12-р сард ОТ болон Малчдын төлөөлөл (МТ) нь ОУСК-ийн Эрх зүйн хяналт, зөвлөгөө, омбудсмэний газар ("ЭЗХЗОГ")-с чиглүүлэн явуулдаг уулзалтуудыг орон нутгийн оролцогч талуудын дунд тогтмол хэлэлцүүлэг байдлаар хийж, Ундай голын голдирылд хийх тохируулгыг цаашид хэлэлцэхээр тохиролцсон. Оролцогч талуудад ОТ, Малчдын төлөөлөл, Ханбогд сумын захиргаа багтана. Эдгээр талууд хамтдаа Гурван талт зөвлөлийг бүрдүүлнэ. Гурван талт зөвлөлийн хурлаар Ундай голын уурхайн лицензийн талбайгаар өнгөрч буй хэсэгт ууршилт үүсэхээс сэргийлэх, одоогийн усны нөөцийг хадгалах зэрэгтэй холбоотой арга хэмжээ хэрэгжүүлэх тодорхой нөхцөлтэйгээр Ундай голд хэсэгчлэн тохируулга хийх, хамгаалах төслийн асуудлаар тохиролцоонд хүрсэн. ОТ холбогдох бүх гомдол, саналыг нэг бүрчлэн авч үзсэн. Ундай голын тохируулгын асуудлаар эцсийн байдлаар тохиролцоонд хүрсэн тухай Өөрчлөлтийн мэдэгдлийг 2017 оны 5-р сарын сүүлээр Зээлдүүлэгч нарт өргөн барьснаар 2016 оны 6-р сард батлагдсан (Өөрчлөлтийн мэдэгдэл 2016 – 014).



Гурван талт зөвлөл (ГТЗ), усны сав газрын захиргаа, бусад талуудтай хамтран гидрогеологийн судалгаагаар гидравлик холбоотой болох нь тогтоогдсон бүх цооногуудыг актлах ажлыг ОТ зохион байгуулсан. Гүний хоолойн орчим, уурхайн лицензийн талбай, ОТ-н идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй газруудад (өөрөөр хэлбэл ил уурхай, ус зайлуулах сүвгүүд, ХХБ-ийн дээд, доод үрсгал гэх мэт) нийт 37 хяналтын цооног байгуулах юм. 2016 оны байдлаар нийт 20 нэмэлт цооног гаргасан байсан. 2017 онд нийт 9 хяналтын цооног (дээрх гурван байршилд) нэмж байгуулсан байна.

ОТ 1 тонн хүдэр боловсруулахад Гүний хоолойн уст давхрагаас дунджаар 423 литр боловсруулаагүй ус буюу бага зэргийн давсны агууламжтай ус хэрэглэдэг. Энэ нь нэг тонн хүдэр боловсруулахад 547 литр ус зарцуулна гэсэн зорилтот хэмжээнээс хамаагүй бага үзүүлэлт бөгөөд 1,220 литр зарцуулдаг дэлхийн дундаж үзүүлэлттэй харьцуулахад усны хэрэглээ хамаагүй багатайг илтгэх үзүүлэлт юм. 2016 онд нийт хэрэглэсэн усныхаа 86,6%-ийг дахин боловсруулан ашигласан нь 2015 онд 85,5% байсан үг үзүүлэлт сайжирсныг харуулж байна. Дахин боловсруулан хэрэглэх усны хэмжээ 80% байхаар заасан Гүйцэтгэлийн гол үзүүлэлтээс дээрх хоёр жилийн үзүүлэлт хоёулаа сайн байгаа юм.

#### **Эрдэсийн хаягдлын менежмент**

Ил уурхай, Хаягдал чулуулгийн овоолго (ХЧО), Хаягдал хадгалах байгууламж (ХХБ)–аас гарах эрдсийн хаягдлын менежментийг Төслийн стратегид заасны дагуу хэрэгжүүлсээр байна. Овоолсон хаягдал чулуулгыг Хүчил үүсгэх чадвартай (ХҮЧ-тай) материал, Хүчил үүсгэх чадваргүй (ХҮЧ-гүй) материал гэж ангилан ялгах, геотехникийн ExPit програмаар Эрдэс хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу хяналт шинжилгээ хийх шаардлагатай. Гүний уурхайн бүтээн байгуулалтын ажил үргэлжилж байгаатай холбоотойгоор хаягдал чулуулгыг шинээр байгуулсан Хүчил үүсгэх чадвар (ХҮЧ)-тай материалд зориулсан хаягдал чулуулгийн нэгдсэн шинэ овоолго руу зөөвөрлөж байна. Өмнөд хаягдлын овоолгын зах хэсэгт ХЧО-ыг ургамалжуулах туршилтын төслийн хүрээнд лизиметр хэмжих багаж суурилуулах зэрэг эхний шатны ажлууд хийж эхэлсэн ба цаашид ХҮЧ-гүй болон ХҮЧ-тай эрдэсийн хаягдлын хучилт хийх, шимт хөрс, ургамлан давхаргыг байгуулах ажлуудыг тус туршилтын талбайд хийх юм. Өмнөд ХЧО-ын нөхөн сэргээлтийн урьдчилсан төлөвлөгөөнд хүчтэй эвдрэлд орсон болон чийг барилт нь өөр өөр налуу хэсгийн нөхөн сэргээлтийг тусдаа туршилтын талбайд хийхээр төлөвлөсөн байна.

Баяжуулах үйлдвэрээс гарах хаягдлыг ХХБ руу шахан зайлуулж, үйлдвэрийн/технологийн ус гаргаж авна. Одоогоор ХХБ-ийн 1-р бассейныг ашиглаж байна. Хаягдал хуримтлуулахад зориулсан далангийн барилгын ажил 2017 онд 50-80 хувийн гүйцэтгэлтэй байхаар төлөвлөж байна. Шахуургын станцыг ашиглан ХХБ дээр эргүүлэн татах усны менежментийг үр дүнтэй явуулсан. Геотехникийн нөхцөлийг тодорхойлох, авч үзэхэд хяналт чухал ач холбогдолтой учир ОТ хэмжилтийн багаж хэрэгсэл нэмэлтээр суурилуулж, ХХБ-ийн Барилгын ажил, ашиглалт, хяналт шинжилгээний гарын авлагыг шинэчлэн сайжруулсан. ХХБ-ийн зүүн хойд хэсгийн улнаас гарч буй шүүрэл нь байгууламжийн төлөвлөгөө, тооцооны дагуу байгаа бөгөөд хяналт шинжилгээ тогтмол хийж байгаа. Ус эргүүлэн татах цөөрөм болон шүүрсэн усан дахь ууссан хатуу бодисын нийт хэмжээ (УХБНХ), давсны агууламж өндөр байна. ХХБ-ийн зураг төсөлд заасны дагуу шүүрсэн усыг хуримтлуулсны дараа ХХБ руу буцаан шахаж, Баяжуулах үйлдвэр рүү татна. ХХБ-ийн хашааны өмнөд хэсгийн дагуу ажиглагдсан өнгөн хөрсний шүүрэлд фезометр, хяналтын цооногууд ашиглан өргөтгөсөн хөтөлбөрөөр хяналт шинжилгээ хийж байна.

ХХБ-ийн ТЭЗҮ-ийг 2016 оны 12-р сард шинэчлэн сайжруулж, төлөвлөж буй 2-р бассейны үрсгалын доод хэсэг дэх налуугийн уналт, шүүлтүүрийн хэсэг зэрэг боломжит сайжруулалтуудыг тусгасан ба эдгээрт хөндлөнгийн техникийн үнэлгээ хийж дуусахыг хүлээж байна.

#### **Эрдэсийн бус хаягдлын менежмент**

Үйлдвэрлэлийн явцад гаргаж байгаа бүх хог хаягдлын менежментээ Төсөл зуун хувь өөрийн хүчин чадлаар зохицуулж байна. БОНХЗ сүүлд уурхайд ажилласнаас хойш Дахин боловсруулах хаягдал түр хадгалах төв (ДБХТХТ)-д хог хаягдал хадгалахаа бүрмөсөн зогсоосноос гадна, барилга угсралтын үе шатны үлдэгдэл хог хаягдлыг хүртэл Хаягдлын менежментийн төв (ХМТ)-д шилжүүлж эсвэл дотоодын дахин боловсруулах үйлдвэрүүдэд өгч, дахин боловсруулалтад оруулж байна. Хаягдлын гарцын хувьд, хамгийн сүүлд хийсэн тооцоогоор, одоо ашиглагдаж байгаа нэгдүгээр үүр 2018 оны 2-р улиралд дүүрэхээр байгаа.

Нэмэлт хоёр үүр барих газар шорооны ажил дууссан ба цаашид ажиллагаанд оруулах капитал ажлуудыг дараа жил хийхээр баталсан байна.

БОНХЗ 2016 оны 8-р сард аудит хийх үед хог хаягдлыг ДБХТХТ-д хадгалж байсны дээр дахин боловсруулах дотоодын үйлдвэрүүдтэй гэрээгээ шинэчлэх хугацааг тодорхой тогтоогүй байсан тул үүнийг I ангиллын зөрчилд оруулсан. Харин энэ удаагийн аудитын үеэр хэд хэдэн төрлийн хаягдлыг дахин боловсруулалтад оруулахаар дотоодын компаниудтай байгуулсан гэрээг БОНХЗ-д танилцуулсан тул уг Төслийг одоо Хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан зарчим, стратегитай нийцэж байна гэж үзэн уг зөрчлийг хаасан болно.

Хог хаягдлын менежемент, хаяж зайлуулж буй байдалд гарсан бас нэг томоохон өөрчлөлт нь шатаах зуухыг ашиглалтаас гаргаж, оронд нь эмнэлгийн хаягдал шатаах зориулалттай шинэ зуух ашиглах болсон хэрэг юм.

#### **Агаарын чанар**

Том ширхэгтэй хүдрийн овоолгын (ТШХО) байгууламжид ер нь их хэмжээний тоос үүсэж байдаг. Уг тоосыг бууруулах зорилгоор хөөсөөр тоос дарах систем (гадаргуун идэвхит бодисын систем) суурилуулсан. Ингэснээр ТШХО байгууламж доторх агаарт тогтсон нийт тоосны нягтрал (TSP) мэдэгдэхүйц багассан байна. Гэхдээ орчны агаар дахь бодисын хяналт шинжилгээний мэдээнээс үзэхэд төслийн стандартад заасан хэмжээнээс хэтэрсэн хэвээр байна. Өнгөрсөн жилд энэ чиглэлээр томоохон сайжруулалтуудыг хийсэн. Үүнд туузан дамжуургын төгсгөл хэсэгт канвас таг суурилуулах, нунтаглагч тээрмийн (ХӨН) буцах эргэлт дээрх материал буцалтыг багасгах зорилгоор шүүр тавих, цэвэрлэгээ хийх үеийн аюулгүй ажиллагааг хангах үүднээс дамжуургын дор хамгаалалтын тор тавих зэрэг ажлууд багтана. Хөөсөөр тоосжилт дарах бага оврын системийг туузан дамжуургаас ХӨН тээрэм рүү чиглэсэн туннелүүдэд туршиж байна. Хэрэв эдгээр туршилт амжилттай болвол хөөсөөр тоосжилт дарах байнгын систем суурилуулж болох юм.

Өмнөх аудитаар тэмдэглэж байсанчлан, орчны агаарын чанарыг төслийн стандартад нийцүүлэхийн тулд уурхайн одоогийн орчны агаарын хяналт шинжилгээний сүлжээг сайжруулах, нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг үнэлэх шаардлагатай байна. 2016 оны 4-р улиралд хэрэгцээт тоног төхөөрөмжийг уурхайд авчирсан. Тоног төхөөрөмж, туршилтын үйл ажиллагаанд шаардагдах эрчим хүчний эх үүсвэрийг суурилуулах зэрэг техник ажлуудыг хийж дууссан. Бүрэн ашиглалтад оруулах, уурхайд сургалт явуулах ажлуудыг 2017 оны 3-р улиралд төлөвлөсөн ба энэ үеэр тоног төхөөрөмжийг ажиллагаанд оруулна.

Дулааны төв станцын утааны чанар Төслийн стандартад хүрэхгүй асуудал удаа дараа тавигдсаар ирсэн. Хөндлөнгийн байгууллагаас уг Станцын утаанд шинжилгээ хийж буй байдалд шалгалт хийж, одоо ашиглаж байгаа дээж авах аргачлалд хэд хэдэн ноцтой дутагдал байгааг илрүүлсэн. Агаарын чанарын хяналт шинжилгээний төлөвлөгөөнд шаардсаны дагуу Дулааны төв станцын хүчин чадлыг 130 мВт болгох 2 дахь шатны өргөтгөлийн ажлын хүрээнд Утааны тогтмол хяналт шинжилгээний систем (УТХШС)-ийг үндсэн нэг янданд суурилуулна. Бүх бойлеруудад өндөр хэмд тэсвэртэй материалаар бүрэн засвар хийж, 1500 гаруй уутат шүүлтүүр сольсон зэрэг ДТС-ын бусад сайжруулалтын ажлууд хийгээд байна.

Шатаах зуухны ажиллагаатай холбоотойгоор утааны чанарын үзүүлэлт нь Төслийн стандартад хүрэхгүй асуудал урт хугацаанд үргэлжилж байна. ОТ үүнээс хойш сар бүр гардаг 100 кг орчим эмнэлгийн хог хаягдлыг шатаалгаар автоклавтай нэг копанитай гэрээ байгуулсан. Тос арчсан даавуу материал зэрэг бусад аюултай хог хаягдлын урсгалыг Хаягдлын менежментийн төвд тусад нь шугам гаргаж эсвэл дахин боловсруулалт хийх өөр санал санаачлагаар зохицуулж болох юм. Энэ жилийн эцэс гэхэд (а) уг шатаах зуухыг бүрэн ашиглалтаас гаргаж, дахин ашиглахаа больсон байх; (b) автоклавыг бүрэн ашиглалтад оруулсан байх шаардлагатай.

ОТ хүлэмжийн хийн ялгарлын (ХХЯ) хэмжээг бүртгэдэг бөгөөд 2016 онд нийт 1,429,619 CO<sub>2</sub>(eq) бүртгэгдсэн. Энэ нь 2015 онд бүртгэгдсэн 1,463,057 тонн CO<sub>2</sub>-тэй харьцуулахад харьцангуй тогтвортой үзүүлэлт юм. 2015 онд ялгаруулсан нүүрсхүчлийн хийн 80% нь 2-р хүрээнд хамаарах эх үүсвэрээс эрчим хүч худалдан

авсантай холбоотойгоор 1,159,647 CO<sub>2</sub> (eq) бүртгэгдсэн. 1-р хүрээнд хамаарах шууд эх үүсвэрээс ялгарсан нүүрсхүчлийн хийн хэмжээ нь 269,972 CO<sub>2</sub> (eq) байсан бол 3-р хүрээнд хамаарах шууд бус эх үүсвэрээс үүссэн нүүрсхүчлийн хэмжээ маш бага байгаа юм.

Хөндлөнгийн байгууллагаас *Оюу толгойн хүлэмжийн хийн ялгаруулалтад үнэлгээ хийсэн тайланг* 2016 онд гаргасан. Хүлэмжийн хийг 2016 онд гаргасан *Рио Тинтогийн Хүлэмжийн хий, эрчим хүчний хэрэглээний ажлын журналд* заасан аргачлалаар бүртгэдэг. Рио Тинтогийн хүлэмжийн хийн бүртгэл нь Дэлхийн тогтвортой хөгжлийн бизнесийн зөвлөл/Дэлхийн нөөцийн институтийн Хүлэмжийн хийн протоколд тусгасан тодорхойлолтуудад үндэслэсэн байдаг.

***Онцгой байдлын үеийн бэлэн байдал, авах арга хэмжээ***

Онцгой байдлын үеийн бэлэн байдал, авах арга хэмжээний төлөвлөгөө (ОБЕББААХТ) дагуу өндөр болон ноцтой эрсдэл бүхий салбар/үйл ажиллагаанд гарч болзошгүй ослыг удирдах онцгой байдлын үед авах арга хэмжээний журмыг шинэчлэн боловсруулсан байна. Уурхайд бүхэлд нь болон тухайн ажлын талбар/хэлтэст учирч болзошгүй эрсдэлд чиглэсэн арван таван онцгой байдлын үед авах арга хэмжээний журам боловсруулж, 2017 онд хэд хэдэн журмыг хянан үзэх, шинэчлэхээр төлөвлөсөн. Онцгой байдлын баг, Орон нутгийн харилцааны баг хамтран холбогдох төрийн байгууллагын ажилтнуудыг ХХБ-тай танилцуулах ажлыг санаачилж, ХХБ-ийн Онцгой байдлын үед авах арга хэмжээний журмыг хувилан тарааж, ослын үед холбоо барих мэдээлэл, ХХБ-ийн ажилтнуудын мэдээллийг шинэчлэх журмыг шинэчлэн сайжруулсан байна. Нутгийн иргэдэд ХХБ, онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөний талаар товч танилцуулахаар төлөвлөсөн байснаа түр зогсоосон ба ХХБ-ийн далан эвдэрсэн тохиолдолд хаягдал урсах цар хэмжээ хүрээг тодорхойлох дүн шинжилгээ хийсэн. Энэ дүн шинжилгээг одоогоор эцэслэн боловсруулж байгаа бөгөөд онцгой байдлын хамрах газар нутгийг тодорхойлоход ашиглагдсан өмнөх дүн шинжилгээтэй харьцуулан дахин хянаж үзэх шаардлагатай. ХХБ-ийн Онцгой байдлын үед авах арга хэмжээний журамд багтсан хариу арга хэмжээг хэрэгжүүлэх хамрах газар нутгийн зурагт ямар нэг өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг тодорхойлж, орон нутгийн холбогдох албаны хүмүүс, иргэдтэй хамтран өөрчлөлтийг тусгаж өгнө. ХХБ-ийн орон нутгийн иргэд, оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөөг 2017 оны сүүлээр эцэслэх бөгөөд үүнд онцгой байдлын хариу арга хэмжээ авах хамрах газар, ослын үеийн бэлэн байдлыг хангах арга хэмжээ зэрэг багтана.

Гүний уурхайн онцгой байдлын төлөвлөгөөг 2017 оны 1-р сард шинэчилж, Уул уурхайн яаманд хүргүүлсэн бөгөөд уг төлөвлөгөөнд 2017 оны эхний зургаан сард гүний уурхайн бүтээн байгуулалттай холбоотой гол хийгдэж буй ажлуудыг тусгасан.

### **Тээврийн менежмент**

Тээврийн үйлчилгээ үзүүлдэг компаниуд танилцуулах сургалт, орон нутаг, байгаль орчны мэдлэг олгох сургалтын хөтөлбөрүүдийг тогтмол хэрэгжүүлж байгаагаас гадна SmartCap (операторт шууд тухайн цагт нь сэрэмжлүүлэг өгдөг), Readiband (нойрны хэмнэлийн талаар илүү ойлголттой болоход туслах) технологийг ашиглах зэргээр зэсийн баяжмал тээвэрлэж байгаа операторуудын алжаал ядаргаанд хяналт тавих, удирдах хөтөлбөрийг бүрэн нэвтрүүлсэн. Эрүүл мэндэд эрсдэл учруулахаас сэргийлэх үүднээс алжаал ядаргааг хянах, удирдах тус хөтөлбөрийг Эрүүл мэндийн хэлтэстэй хамтран хэрэгжүүлж байна.

Хилийн боомтод нүүрсний тээврийн хөдөлгөөн нэмэгдсэн, тээврийн хэрэгслийг хилээр нэвтрүүлэх үйл явцад өөрчлөлт орсонтой холбоотойгоор 2016 оны эцсээр цуваанд явсан машинууд мөргөлдсөн зэрэг хэд хэдэн зам тээврийн осол гарсан нь үйл ажиллагаа, аюулгүй ажиллагаатай холбоотой эдгээр асуудлуудад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх хэрэгтэйг ОТ-д сануулж байна.

### **Экологийн менежмент, биологийн олон янз байдал**

ОТ-н биологийн олон янз байдлыг төлөвлөгөөнүүд нь ОТ-н биологийн олон янз байдлын хяналт шинжилгээний ажлуудыг төлөвлөх, биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг удирдах, шаардлагатай тохиолдолд менежментийн хариу арга хэмжээнүүдээ шинэчлэн өөрчлөх, дүйцүүлэн хамгаалах төслүүд хэрэгжүүлэх тогтолцоо болж өгдөг. Биологийн олон янз байдлын чиглэлээр Оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө (ОТХАТ)-нд тодорхой хамтын ажиллагаанууд, тэр дундаа дүйцүүлэн хамгаалах, улсын болон бүс нутгийн хэмжээнд хамтын ажиллагааг зохих түвшинд хөгжүүлэхэд шаардагдах хамтын ажиллагааны хөтөлбөрийг тусгаж өгдөг.

#### *Цахилгаан дамжуулах шугамтай холбоотой нөлөөллийг удирдан зохицуулах*

ОТ дүйцүүлэн хамгаалах төслийн хүрээнд өөрийн эзэмшлийн цахилгаан дамжуулах шугамд тусгаарлагч суурилуулсан бөгөөд улмаар ОТ эзэмшлийн бус шугамд суурилуулах туршилт эхлүүлсэн. Эхний байдлаар хяналт-шинжилгээ хийхэд нэгж өндөр хүчдэлийн шон мөргөх бодьгалийн тоо дундажаар 0.25 байснаа 0.05-с бага болж буурсан эерэг үр дүн харагдаж байна. ОТ-н эзэмшлийн бус шугамд нөлөөллийг бууруулах арга хэмжээ хэрэгжүүлсний дараа судалгаа хийхэд тусгаарлагч суурилуулахаас өмнө 29 бодгаль мөргөдөг байсан өндөр хүчдэлийн шугамд тусгаарлагч суурилуулснаас хойш нэг эдлэг шонхор мөргөсөн дүн гарсан. Өндөр хүчдэлийн шугамд тусгаарлагч суурилуулахын ашиг тусыг Монгол орны хэмжээнд илүү өргөн хүрээнд дэлгэрүүлэх ажлын хүрээнд ОТ Өндөр хүчдэлийн шугамын улсын стандарт шинээр боловсруулах ажлын хэсэгт орж ажиллаж байгаа бөгөөд ОТ-н эзэмшлийн бус шугамуудад тусгаарлагч нэмж суурилуулахаар төлөвлөж байна. 2017 оны хийсэн хяналт шинжилгээгээр ОТ-д хоёр хулан жороо хүчдэл мөргөсөн нь бүртгэгдсэн байна.

#### *Оролцогч талуудтай хамтран ажиллах*

ОТ уурхай дахь нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, Үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, бүсийн болон нутаг орны түвшний төлөвлөлттэй уялдуулан хамтын ажиллагааг удирдах, ОТ талуудын оролцоог хангаж, хамтран ажиллаж байгааг Зээлдүүлэгч нарт батлан харуулах үндэслэл болгох зорилгоор Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөнд ОТ-д “зорилтот оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө” (ОТХАТ) боловсруулах үүрэг хүлээлгэсэн. Биологийн олон янз байдлын чиглэлээр ОТХАТ-г боловсруулсан бөгөөд ОТ-н ерөнхий ОТХАТ-ний хавсралт болж орсон. Гэхдээ уг төлөвлөгөөг илүү дэлгэрэнгүй болгох, ОТ-н дүйцүүлэн хамгаалах дөрвөн төслийн хувьд гол хамтран ажиллах үйл ажиллагаануудын төлөвлөлтийг сайжруулахын тулд тухайн сэдэв тус бүрээр талуудтай хамтран ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах шаардлагатайг өмнөх аудитаар тодорхойлсон. ОТ-н дүйцүүлэн хамгаалах дөрвөн төслийн сэдэвчилсэн хамтын ажиллагааны төлөвлөгөө эцсийн байдлаар гарах хүртэл уг зөрчлийг нээлттэй хэвээр үлдээсэн болно.

#### *Экосистемийн үйлчилгээ*

I ангилалд хамаарах энэ зөрчлийг хаасан. Экосистемийн үйлчилгээний хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө (ЭҮХҮХ)-г БОНХЗ-ийн 2016 оны 9-р сард хийсэн аудитын үеэр өгсөн санал, зөвлөмжийн дагуу

шинэчлэн сайжруулсан. Зарим нэг зүйл орхигдсон ч гэсэн энэ зөрчлийг бүрэн арилсанд тооцсон. Дутуу, орхигдсон зүйл байгаа ч гэсэн уг төлөвлөгөөг одооноос хэрэгжүүлэхийг зөвлөж байна. ОТ төслийн ерөнхий зорилго, одоо ашиглаж буй шалгуур үзүүлэлт, босго үзүүлэлтүүдийн тохиромжтой байдал зэргийг хангахад энэ төлөвлөгөө хэр үр дүнтэй болохыг БОНХЗ дараагийн удаа уурхайд ирж ажиллахдаа үнэлэх болно.

*Газар хөндөлтөд хяналт тавих, нөхөн сэргээлт хийх*

Ховор ургамлын зүйлд сөрөг нөлөө үзүүлэхээс зайлсхийх

ОТ газар хөндөх төлөвлөгөөт үйл ажиллагаандаа Газар хөндөх төлөвлөгөөний бүртгэлийн журнал хөтөлж, Уурхайн лицензийн талбайгаас олдсон дөрвөн зүйлийн ховор ургамал, газар хөндөх төлөвлөгөөт үйл ажиллагаа явагдах газрын ойр орчим дахь бусад дөрвөн зүйл ургамлын орон зайн тархалтыг харуулсан зургийг ашигладаг. Грубовын хөөндий (*Spongiocarpella grubovii*) бол ОТ эерэг нөлөө ахиу үзүүлэх үүрэг хүлээсэн төрөл зүйлийн нэг бөгөөд уурхайн лицензийн талбайд цөөн хэдэн байршилд, мөн уурхайн талбайн хойд хэсэгт нэг цэгт ургадаг. Уурхайн лицензийн талбайд ургаж байгаа хэсгүүдийн зарим нь уурхайн барилгын үйл ажиллагааны нөлөөнд хэдийнэ өртсөн тул ОТ-н зүгээс одоо энэ зүйл ургамал нэмж сүйдэхээс хатуу зайлсхийж, Грубовын хөөндийн (*S.grubovii*) үржүүлгийн ажилд онцгой ач холбогдол өгөх шаардлагатай. БОНХЗ уурхайд ажиллах үед Ургамал судлалын багийнхан “Уурхайн төлөвлөлтийн хэлтсээс уурхай ашиглалтын төлөвлөгөөг байн байн шинэчлэн, оновчилж байгаатай холбогдуулан ховор зүйл ургамлын байршлын зургийг ашиглахад тохиромжгүй болсон” тухай мэдээлсэн. ОТ энэ асуудлыг судалж, дараагийн аудитаар эргэж хариу өгөх шаардлагатай.

Нутгийн ургамлын үржүүлгийн төвийн түүсэн бага хэмжээний Грубовын хөөндийн (*S.grubovii*) үрийн соёололтыг туршиж үзэх хэрэгтэй байна. Үлдсэн бодьгалиудыг сүйтгэхгүй, байгалийн сэргэн ургалтад нь сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр үр нэмж түүх хэрэгтэй ба тус зүйл ургамлыг нөхөн сэргээх төлөвлөгөө боловсруулах шаардлагатай. Одоогийн байдлаар сөрөг нөлөөлөлд өртөөд байгаа нэг зүйл ургамлыг оруулсан ховор ургамлуудыг нөхөн сэргээх тодорхой стратеги байхгүй байгаа тул энэ асуудлыг зөрчил хэмээн тодорхойлсон болно.

Нөлөөллийг бууруулах, ургамлын үржүүлэг

Нутгийн ургамлын үржүүлгийн төв үйл ажиллагаа явуулаад зургаан жил болж байна. Говийн бүсэд ургадаг зүйл ургамлуудаас гадна дор тэмдэглэсэнчлэн, хэдийгээр ОТ биологийн нөхөн сэргээлтийн ажлыг нэн тэргүүнд тавихгүй байгаа ч гэсэн биологийн нөхөн сэргээлтэд ашиглах зорилгоор ургамлын суулгац, тарьц үржүүлэх аргачлал боловсруулах чиглэлээр маш үр дүнтэй ажиллаж ирсэн. Нутгийн ургамлын үржүүлгийн төвийг 2017 оны 7-р сараас эхлэн Экоминерал компани удирдан ажиллуулахаар болсон. Дараагийн аудитаар ОТ нөхөн сэргээлт хийхэд тохиромжтой нутгийн ургамлын нөөц хангалттай бүрдүүлж чадсан эсэх, менежментийг шилжүүлсэн нь гол судалгаа хийх нөөцөд нөлөө үзүүлсэн эсэхэд шалгалт хийх болно.

Техникийн болон биологийн нөхөн сэргээлт

ОТ засгийн газарт танилцуулж, батлуулсан техникийн нөхөн сэргээлт хийх амлалтаа өнгөрсөн хоёр жилд биелүүлж чадаагүй. Өөрөөр хэлбэл, 2015 онд 140 га-д нөхөн сэргээлт хийхээр төлөвлөөд 120 га-д, 2016 онд 43 га-д төлөвлөөд 33 га-д нөхөн сэргээлт хийсэн байна. 2017 онд ОТ нөхөн сэргээлт хийхээр төлөвлөж буй газрын хэмжээгээ ихээхэн хэмжээгээр бууруулж засгийн газарт танилцуулсан. 2012-2016 онд нийт 367 га газарт биологийн нөхөн сэргээлт хийсэн бол 2016 онд 93 га-д биологийн нөхөн сэргээлт хийсэн. Газар хөндөх зөвшөөрөл авахдаа тухайн жил нөхөн сэргээлт хийх газрын хэмжээг зөвшөөрөл авч буй газрын хэмжээтэй уялдуулан илүү бодитой тусгах замаар оновчтой тогтоох хэрэгтэй. Өнгөрсөн аудитаас хойш биологийн нөхөн сэргээлт хийсэн газрын хэмжээ буурсан тул ургамалжуулах ажлыг хэрэгжүүлсэнд тооцох үзүүлэлтийг доош татсан.

Техникийн нөхөн сэргээлт хийснээс хойш байгалийн сэргэн ургалт нь явагдах хүртэл урт удаан хугацаа шаардагддаг учраас биологийн нөхөн сэргээлт хийх нь илүү үр дүнтэй гэдгийг ОТ ойлгох хэрэгтэй. ОТ уурхайн лицензийн талбайд биологийн нөхөн сэргээлт хийх ажлыг нэн тэргүүнд тавьж үзэхгүй байна.

Гэхдээ үнэхээр байдал ийм байгаа эсэхийг магадлахын тулд зарим нэг түршилтүүд хийж үзэх хэрэгтэй. Энэ аргачлалын эрсдэлтэй тал нь ОТ ховор ургамлын зүйлийн (жишээ нь Грубовын хөөндий зэрэг) үрийг үржүүлэх боломжтойг нотлон харуулах гэсээр байтал тухайн зүйл бүхий чухал амьдрах орчин нөлөөлөлд өртсөн тохиолдолд уурхайн талбар дахь тэдгээр зүйлүүд устаж үгүй болох аюултайд оршино. Ингэснээр төслийн хувьд чухал амьдрах орчин шаардлагатай дөрвөн зүйл болоод бусад дөрвөн зүйл ховор ургамалд эерэг нөлөө ахиу үзүүлэх амлалтаасаа гадна засгийн газрын зүгээс тавих шаардлагуудыг биелүүлж чадахгүйд хүрэх эрсдэлтэй. Сүүлд хийсэн газрын судалгаанаас үзэхэд Грубовын хөөндийн бүлгэмдэл зөвхөн уурхайн лицензийн талбайн хойд хэсэгт тэлсэн байгааг БОНХЗ онцлон тэмдэглэж байна.

Ургамлын багийн хүн хүч тавин хувиар буурсан ч ажлын ачаалал хэвээр байна. Экоминерал зэрэг гэрээт компаниудтай хамтран ажилласнаар энэ асуудлыг анхаарч үзэх юм байна гэж ойлгосон.

#### Бор Овоогийн булаг

Гурван талт зөвлөлтэй хамтран ажилласны үр дүнд Булгийн орчмын хоёр га газрыг хашаалж, хамгаалалтад авахаар шинэчлэн тодорхойлсон ургамлуудыг мал идэхээс хамгаалсан. 2016 оны 10-р сарын сүүлээр Нутгийн ургамал үржүүлгийн төвд бойжуулсан суулгацыг тус хашаалсан талбайд суулгасан. Экоминерал 2017 оны 7-р сараас эхлэн гурван жилийн гэрээ байгуулж, мөхсөн ургамлыг шинээр тарьж ургуулах, 2017 оны 5-р сард БОНХЗ уурхайд аудит хийх үед эвдэрсэн байдалтай байсан хашаа хайсыг засч сэргээх үүрэгтэй ажиллах юм. Өмнөх аудитаас хойш ургамалжуулах ажлыг хийсэнд тооцох тодорхой үзүүлэлтийг боловсруулж, батлуулсан байна. 2017 оны 8-р сард эдгээр үзүүлэлтүүдийн дагуу үнэлгээ хийж, үр дүнг тайлагнах ба дараагийн удаа уурхайд аудит хийх үеэр дахин хянаж үзнэ.

#### Хаягдал чулуулгын овоолгыг ургамалжуулах түршилт

ОТ хаягдал чулуулгын овоолгын түршилтын талбайд ил уурхайгаас тохирох төрлийн Хүчил үүсгэх чадамж (ХҮЧ)-тай чулуулаг гарахыг хүлээж байгаатай холбоотойгоор ургамалжуулах түршилт хараахан эхлээгүй байна.

#### *Замын хөдөлгөөн, тээвэртэй холбоотой нөлөөллийг удирдах*

Өмнөх аудитаас хойш ОТ-н баяжмалын цуваанд явсан машинд нэг хулан мөргүүлж, үхсэн тохиолдол 2016 оны 12-р сарын 28-нд гарсан байна. Мөн 2017 оны 2-р сард ХХБ-ийн замд (уурхайн талбай дахь) нэг хар сүүлт үхсэн байна. ОТ БОЯБҮАТ13-ын дагуу ОТ-Гашуунсүхайд чиглэлийн автозамын нөлөөллийг бууруулах стратеги боловсруулж, хэрэгжүүлэх ёстой. 2016 онд Зээлдүүлэгч нарт хянуулахаар өргөн барьсан Замын нөлөөллийг бууруулах стратегийн төсөл нь БОЯБҮАТ-тэй нийцэхгүй байна гэж үзсэн.

ОТ-н Замын нөлөөллийг бууруулах стратеги (БОЯБҮАТ4)-тай холбоотой техникийн цуврал асуудлуудад хараат бус дүгнэлт гаргах, санал зөвлөмж өгөх зорилгоор ОТ Замын нөлөөллийг бууруулах стратегийн зөвлөл ("Зөвлөл" гэх) байгуулсан. Тус зөвлөл нь 2017 оны 2-р сарын 23-нд анхны хуралдаанаа хийж, гишүүд нь 2017 оны 5-р сарын 10-17-ны хооронд уурхайд ажилласан. Зөвлөл 2017 оны 7-р сарын 31 гэхэд тайлангаа эцэслэн гаргана.

БОНХЗ тус Зөвлөлийн тайланг хянаж үзэх боломжгүй тохиолдолд зөвлөлийн даргатай теле-хэлэлцүүлэг хийхийг ОТ болон зээлдүүлэгч нар зөвшөөрсөн болно. Энэ удаагийн аудитаар шинэ мэдээлэлтэй танилцах боломж байхгүй байсан тул Зөвлөлийн тайлан эцсийн байдлаар гарч аудиторруудад танилцуулсны дараа энэ зөрчлийг дахин үнэлэх болно.

#### *Бохирдлын нөлөөллийг удирдах*

#### Тоосжилтын хяналт-шинжилгээ

БОНХЗ-ийн өмнөх аудитын тайланд сүүлийн 3.5 жилийн хугацаанд ОТ-н ургамлын байнгын хяналт-шинжилгээний 32 талбайд нөөц хуваарилагдаагүй тухай дурдсан билээ. ОТ ялангуяа Ханбогдын чиглэлийн автозамын дагуух ургамал ургалтад тоосжилт сөрөг нөлөө үзүүлж буй эсэхэд хяналт-шинжилгээ хийх гадны гэрээт компани ажиллуулах хүсэлтийг хангамжийн хэлтэст гаргасан гэж мэдээлсэн.

Селен

ОТ селений түвшинд хяналт тавьж ирсэн бөгөөд дүнг нь ХХБ-ын шүүрэлтийн улирлын хяналт шинжилгээний тайланд тусгадаг. Ийн хяналт шинжилгээ хийхдээ, хорт бодисын болзошгүй үр нөлөөтэй холбоотой эрсдэлийг үнэлэх зорилгоор шувууны тооллого хийдэг. Өмнөх аудитаас хойш селений түвшин шувуудад хор нөлөө үзүүлэх тодорхойлсон түвшингээс хангалттай доогуур байсан байна. Уст цэгүүдэд ажиглагдсан зүйл шувууд нь голдуу хамгаалалтад авах шаардлагагүй нүүдлийн шувууд байсан. 2017 оны 5-р сард ангир (Ruddy Shelduck) үүрээ зассан нь батлагдсан ч энэ зүйл шувуу нь хамгаалалтад авах шаардлагагүй зүйлд хамаардаг.

ХХБ дахь селений хэмжээ хорт түвшнээс хэтрэх боломжтой, шувууд орж ирэх боломж нь нээлттэй хэвээр байгаа, ХХБ-д зарим зүйлүүдийн үржил явагдаж байгаа, хамгаалалтад авах шаардлагатай зүйлүүд (устаж болзошгүй ангилалд багтах могойч бүргэд, эмзэг ангилалд багтах идлэг шонхор зэрэг) цаашид нөлөөлөлд өртөж болзошгүй зэргээс үүдэн ХХБ дахь селенийн түвшин, шувуудын селений хэрэглээнд хяналт шинжилгээг тогтмол хийх нь зүйтэй. Ирээдүйд селенийн түвшин нэмэгдсэн тохиолдол илэрвэл шувуудад ажиглалт хяналт тавих илүү системтэй арга ашиглаж, шувуудын суурьших хугацаа, селенийн түвшин нэмэгдсэнээр үзүүлэх нөлөөллийг тодорхойлох шаардлагатай.

Биологийн олон янз байдлын популяцид сөрөг нөлөө үзүүлсэн тохиолдол өмнөх аудитаас хойш гараагүй байна.

*Эерэг нөлөө ахиу үзүүлэх, дүйцүүлэн хамгаалах менежментийн төлөвлөгөө*

ОТ Эерэг нөлөө ахиу үзүүлэх урьдчилсан тооцоо болон Дүйцүүлэн хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгасан дагуу ОТ биологийн олон янз байдалд үлдэх нөлөөллийг бууруулахад чиглэсэн ажлууд хэрэгжүүлэх, улмаар Өмнийн говийн биологийн олон янз байдалд эерэг нөлөө ахиу үзүүлэхэд дэмжлэг болох ажлуудыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Аудит хийх үед ОТ-н биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах дөрвөн төслийн ахиц явцын талаар мэдээлэл өгсөн.

ОТ-н Тогтвортой ноолуур төсөл (ТНТ) улсаас дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаанд тавих шаардлагуудыг хангасан гэж үзэн, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам албан ёсоор баталсан зэрэг өмнөх аудитаас хойш гарсан амжилт ололтуудыг дурдах нь зүйтэй. Улсаас тавих шаардлагуудыг хангаснаар тухайн газарт өгөх үр ашиг, амьдрах орчны чанарын талаас авч үзвэл Тогтвортой ноолуур төсөл улсын хэмжээнд ихээхэн ач холбогдолтой болж байна. Дараагийн нэг амжилтыг дурдвал, Шинжлэх ухааны академи, Зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэгтэй хамтран төмөр замын хашаа хайсыг дахин загварчлах, төмөр замын хайсыг авах, хяналт-шинжилгээ хийх түршилтын төсөл хэрэгжүүлэх зөвшөөрлийг төмөр замын удирдах газраас авсан байна. ОТ түршилтын төслийн ажлын хамрах хүрээнд нийгэм-эдийн засгийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тусгаж, туурайтан амьтдын шилжилт хөдөлгөөнд хяналт-шинжилгээ хийхээр болсон. ОТ дүйцүүлэн хамгаалах төслийн хүрээнд өөрийн эзэмшлийн цахилгаан дамжуулах шугамуудад тусгаарлагч суурилуулсанаас гадна эзэмшлийн бус шугамуудад тусгаарлагч суурилуулах ажлыг түршиж байна.

*Хяналт шинжилгээ, хөрвөх менежмент*

ОТ Биологийн олон янз байдлын хяналт-шинжилгээний төлөвлөгөөний дагуу ховор зүйлүүдийн бүлгэмдэлд хяналт-шинжилгээ хийх ажлаа үргэлжлүүлсээр байна. Энэ ажлыг Зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг, Састэнэбилити (Sustainability) компанитай хамтран гүйцэтгэж байна. 2016 оны Биологийн олон янз байдлын хяналт шинжилгээний ажил Өмнийн говийн бүс дэх хулан (*Equus hemionus*), могойч бүргэд (*Circaetus gallicus*), хайлаас (*Ulmus pumila*), газрын гадаргууд түрэн гарч ирсэн боржинт хэсгийн урамлын бүлгэмдэл, ховор ургамал, бэлчээрт голлон анхаарч байна. 2016 онд цуглуулсан мэдээнд тулгуурлан хэд хэдэн санал зөвлөмж өгсөн. ОТ тэдгээр санал зөвлөмжийг бүгдийг нь хэрэгжүүлэх үүрэггүй ч гэсэн хяналт шинжилгээний ажлын хувьд тодорхой хариу өгч, үндэслэл боловсруулах нь зүйтэй. Ингэснээр ач холбогдлыг бууруулсан шалтгаан нь ойлгогдож, хөрвөх менежмент сонгодог утгаараа хэрэгжих болно.

Оюу толгойн гэрээт компанийн тээврийн хэрэгсэлд мөргүүлсний улмаас нэг хулан үрэгдсэн тохиолдол нь улбар шар босго утга хэтэрсэн биологийн олон янз байдлын цорын ганц үзүүлэлт болоод байна. 2016 оны

хяналт-шинжилгээний дүнгээс харахад өөр ямар нэг үзүүлэлтийн босго утга хэтэрсэн тохиолдол гараагүй байна.

Зарим ховор зүйлүүдийн Улаан дансны ангилал нь өөрчлөгдсөн нь ОТ судалгаа тооллого хийж, хамгааллын үнэлгээ хийхэд илүү дөмөг тоо мэдээ өгсөнтэй холбоотой. ОТ-н ховор зүйлүүдэд учруулах эрсдэлийн мэдээллийг дахин үнэлэх хэрэгтэй ба төсөл хөрвөх менежмент хэрэгжүүлж, холбогдох нөлөөллийг бууруулах арга хэмжээг дахин эрэмбэлэх шаардлагатай.

#### *Хүний нөөц, ажиллах хүч*

ОТ Биологийн олон янз байдлын ахлах зөвлөх томилоод удаагүй байгаа бөгөөд 2017 оны 7-р сараас ажиллаж эхлэх гэж байна. Биологийн олон янз байдлын ахлах зөвлөх нь хоёр жилийн гэрээтэй ажиллах ба түүнээс хойш биологийн олон янз байдал хариуцсан ахлах мэргэжилтэн түүний үүргийг гүйцэтгэх юм.

ОТ-н биологийн олон янз байдлыг хамгаалах багийн ажилтнууд одоогоор ажлынхаа хагасыг Улаанбаатарт байрлаж гүйцэтгэж байгаа нь нэг талаас уурхай даяар зардал хэмнэх санаачлага хэрэгжүүлэх, нөгөө талаас ажилтнуудын ажил, амралтын тэнцвэрийг хадгалах зорилготой холбоотой. Багийнхан уурхайн талбайд ээлжийн хуваариар тогтмол очиж ажиллаж байна. Тус багийнхан ОТ-н эерэг нөлөө ахиу үзүүлэх амлалтын биелэлттэй нийцүүлэн, ажлын байршлаа тэнцвэртэйгээр зохицуулж буй эсэхээ нягтлах шаардлагатай ба уурхайд ажиллах хугацаандаа а) ховор ургамлын үр түүх б) барилгын ажлын цэвэрлэгээ хийх зөвшөөрөл олгохоосоо өмнө Ургамлын мэргэжилтнээр тухайн талбайн ургамлын судалгаа хийлгэхийг шаардсаны үндсэн дээр газар хөндөх зөвшөөрөл олгох зэрэгт анхаарч ажиллах хэрэгтэй. Гол ажилтны эзгүйд газар хөндөх ажиллагаанаас өмнө ховор ургамлын зүйл байгаа эсэхийг шалгах ажлыг цаг хугацаанд нь хийж чадахгүйд хүрч болох юм. Уурхайд ажиллах үед хашаа хайс нурсан зэрэг асуудал Бор Овоогийн булагт ажиглагдсан ба цаашид ажилтнууд тогтмол шалгаж байхгүй бол иймэрхүү асуудлууд анзаарагдахгүй үлдэх эрсдэлтэй. Асуудал үүсэхээс сэргийлж ОТ Уурхайн лицензийн талбайд байнга байрлаж ажиллах, эсвэл үүнтэй төстэй тохиромжтой систем нэвтрүүлэх шаардлагатай.

ОТ нь Зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг, Дэлхийн биологийн олон янз байдлыг хамгаалах холбоо болон 2017 оны 7-р сарын 1-с эхлэн гэрээгээр ажиллаж эхлэх Экоминерал компани зэрэг зөвлөх, мэргэжилтнүүдийн дэмжлэгийг авч ажиллах болно.

#### **Нийгэм**

##### *Хөдөлмөр эрхлэлт, ажлын нөхцөл*

2017 оны 4-р сарын 30-ны байдлаарх ОТ-н Ажиллах хүчний харьцааны тайлангаас үзэхэд ОТ-н үйл ажиллагааны хэсэгт нийт 10,736 ажилтан ажиллаж байгаагийн 2,592 нь ОТ ХХК-ийн үндсэн ажилтнууд, 8,144 нь 155 гэрээт компанийн ажилтнууд байна. Энэ нь уурхай (Гүний уурхай орно), Улаанбаатар, Ханбогдод ажиллаж байгаа ажилтнуудыг нийлүүлсэн тоо юм. Нийт ажилтнуудын 10,010 нь буюу 93.24% нь Монгол ажилтнууд байна. Өмнөговь аймгаас 2,000 ажилтан ажиллаж байна.

Ажиллах хүчийг жигдрүүлэх үйл ажиллагаа үргэлжилж, 2017 оны 11-р сар гэхэд уурхайд дахиад 533 ажилтан шинээр суурьшуулахаар төлөвлөж байгаа ба нийтдээ 5,000-7,000 ажилтан уурхайд байрлаж ажиллах болно.

ОТ уурхайгаас ирэх, буцах нислэгийг цөөрүүлэхийн тулд судалгаа хийж, уурхайд зайлшгүй байрлаж ажиллах шаардлагагүй ажлын байруудыг тодорхойлох, ажиллах хүчний байрны асуудлыг уурхайн талбай дотор шийдэх, ингэснээр Төслийн ойр орчимд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Рөүз төслийг хэрэгжүүлж эхлээд удаагүй байна. 2017 онд нийт 300 орчим ажлын байрыг нийт гурван үе шаттайгаар Улаанбаатар, Даланзадгад, Ханбогд руу шилжүүлэх юм; нүүлгэн шилжүүлэх үйл явц тус орон тоон дахь ажилтнууд уурхай дахь ажлаа алсаас гүйцэтгэхэд шаардагдах МТ-ийн дэд бүтцийг суурилуулахтай холбоотойгоор ээлж дараатайгаар явагдана. ОТ мэдээлэл өгөх уулзалтыг ээлж дараатайгаар зохион байгуулж, энэ хөтөлбөрийн хүрээнд ажилтнуудтай үр дүнтэй хамтран ажиллаж байгааг БОНХЗ-ийн зүгээс тэмдэглэмээр байна.



Гүний уурхайн төслийн өсөн нэмэгдэж байгаа ажиллах хүч зэрэг бүх ажилтнууд одоогоор уурхайд байрлаж байгаа; энэ нь хүн амын шилжин ирэх хөдөлгөөнтэй холбоотой үүсч болзошгүй асуудлуудыг бууруулахад гол үүрэг гүйцэтгэж байна. Уурхайд өдөрт дундажаар 4,576 хүн байрладаг. Оюут II кэмп 2017 оны 12-р сард баригдаж дуусах бөгөөд энэ кэмп үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллах үед дахиад 5,508 хүнийг байрлуулахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Бүх ажилтнуудыг уурхайн лицензийн талбайд байрлуулахад барилга угсралтын ажлын хуваарь ихээхэн нөлөөтэй.

Хятадын эрх бүхий хүмүүстэй ялангуяа, хил орчмын асуудал дээр хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Өвөр Монголын Өөртөө Засах Оронтой хийх түншлэлийн ажлууд явагдсаар байна. ОТ хийсэн эрсдэлийн үнэлгээний үр дүнг Зээлдүүлэгч нарт танилцуулж, ӨМӨЗО-нд оффисоо байгуулснаар эрсдэлээс зохистойгоор сэргийлэх, нөлөөллийг бууруулах, удирдах арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиглэлээр хэрхэн ажиллах талаар танилцуулах хэрэгтэй гэж БОНХЗ-ийн зүгээс зөвлөмөөр байна.

Ажилтнуудын гомдол, саналыг хүлээн авах механизмын үүргийг СпийкАут гүйцэтгэсээр байгаа бөгөөд өмнөх аудитаас хойш 34 гомдол ирсэн байна. Хүлээж авсан гомдол саналын бараг тал хувь нь чухал ач холбогдолгүй хэмээн хаагдсан ба ОТ ялангуяа уг механизмд ажилтнуудын итгэх итгэлийг хадгалахын тулд тэдгээр гомдлыг бүгдийг нь үндэслэлтэйгээр хаасан эсэх, эдгээр хаагдсан гомдлыг дахин авч үзэх шаардлагатай эсэхийг яаралтай дахин нягтлах шаардлагатай.

Хөдөлмөрийн харилцаанд дотоод аудит хийх хөтөлбөр тогтмол хэрэгжсэн бөгөөд томоохон гэрээт компаниудад гэрээт аудитууд ажилласан ба ноцтой зөрчил илрээгүй байна.

Жишиг соёл хөтөлбөр нь ОТ, түүний гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч компаниудад хэрэгжиж эхэлсэн бөгөөд нийт ажиллах хүчний хэмжээнд аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд, сайн сайхан амьдралыг дэмжсэн соёлыг бүрдүүлэх, сургалт, чадавхийг хөгжүүлэх, ажлын байрны нэгдсэн соёлыг хэвшүүлэх, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа явуулах зорилготойгоор амжилттай хэрэгжиж байна.

#### *Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор, амьжиргаа сайжруулах*

ОТ-н үйл ажиллагаатай холбоотойгоор нүүлгэн шилжүүлэх хөтөлбөрт хамрагдсан өрхүүдэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжиж дууссан гэж үзэж байгаа. Гэхдээ ОТ эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөллийг бууруулах үүрэг амлалтынхаа хүрээнд нөлөөлөлд өртсөн малчдад, мөн малчдын амьжиргааг сайжруулах үүрэг амлалтынхаа хүрээнд Ханбогд сумын бүх малчдад дэмжлэг үзүүлэх, хяналт шинжилгээ хийх ажлаа хэсэг хугацаанд үргэлжлүүлэх юм. Өмнө нь ОТ-н замын арчилгаа үйлчилгээний ажил хийж байсан бүх ажилтнууд одоо хөдөлмөрийн гэрээ байгуулсан ба тэд тогтвортой амьжиргааны эх үүсвэртэй болсон, 25 хүнд өөр ажлын байр санал болгосон ба нийт 92 малчныг Тогтвортой амьжиргааг дэмжих сургалтад хамруулсан. Уг сургалтын хөтөлбөрийг шууд нөлөөнд өртсөн малчдад тусгайлан зориулсан боловсруулсан бөгөөд тэдэнд мал аж ахуйгаа тогтвортой эрхлэх, амьжиргаагаа удирдах арга түршлага эзэмшүүлэх зорилготой. Тогтвортой амьжиргааг дэмжих сургалтыг Дорнодын Политехникийн коллеж 2017 оны 12-р сар хүртэл явуулна. Өдийг хүртэл сургалтад хамрагдсан малчдаас дандаа эерэг санал сэтгэгдэл ирсэн, гэхдээ уг хөтөлбөрийн Үр дүнгийн үнэлгээг хийхдээ сургалтад хамрагдагсдын сэтгэл ханамж, сургалтын сэдэв орон нутгийн хэрэгцээ, сонирхолд хэр нийцэж, тохирч байгааг үнэлэхээс гадна малчдын амьжиргаанд үзүүлсэн бодит өөрчлөлтөөр уг хөтөлбөрийн үр дүнг дүгнэхийг ОТ-д зөвлөж байна.

Олон талт шинжээчдийн баг (ОТШБ)-ийн судалгаа хийгдэж дууссан боловч Үр дүнгийн үнэлгээний шаардлагыг хангаж чадахгүй байгаа юм. ОТ энэ ажлыг гүйцэтгэх сонирхолтой байгууллагуудыг Тендерт оролцох сонирхолоо илэрхийлэхийг урьсан зар гаргасан бөгөөд аудит хийх үед хэрэгцээтэй, бодит үр дүн авчрахуйц ажлын хамрах хүрээг нарийвчлан боловсруулахад Зээлдүүлэгчид, БОНХЗ-тэй хамтран ажилласан. Зөрчил М1.23 нь Үр дүнгийн үнэлгээг амжилттай хийх хүртэл нээлттэй хэвээр үлдэнэ.

ОТШБ-ийн судалгаагаар Байгаль орчны хамтын оролцоотой хяналт шинжилгээ (БОХОХШ)-ний хөтөлбөртэй холбоотой гурван гомдол санал гарсан тул БОХОХШ-г Гурван талт зөвлөлтэй хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд хянан үзэх юм. Ийн хянаж үзэхдээ БОХОХШ хийхэд талуудын оролцоог нэмэгдүүлэх, орон нутгийн иргэдэд илүү өргөн хүрээнд үр өгөөжтэй байх тал дээр

анхаарах юм. Тус хөтөлбөрийг 2017 оны сүүлээр шинэчлэн боловсруулж, 2018 оноос хэрэгжүүлж эхэлнэ. БОНХЗ-ийн зүгээс БОХОХШ-ний хөтөлбөрийг шинэчлэн боловсруулахдаа уг хөтөлбөрийн зорилгод (жишээ нь БОХОХШ нь байгаль орчны чиглэлээр хийгдэж буй үйл ажиллагааны чанарыг хангуулах чиглэлээр хамтран ажиллах, малчдын амьжиргааг дэмжих нэмэлт эх үүсвэр болох зэрэг бусад зорилгыг хэрэгжүүлэх механизмын үүрэг гүйцэтгэнэ) нийцүүлэхийг зөвлөж байна. Хөтөлбөрийн зорьж буй үр дүн, зорилгыг ойлгомжтой тодорхойлоход логик хэрэгслийг ашиглаж болох юм.

Ханбогдын хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ОТ Ханбогд сумын удирдлагатай хамтран эмзэг бүлгийн өрхүүдэд дэмжлэг үзүүлэх ажлаа ОТ үргэлжлүүлж байна. Сум жил бүр шалгуур үзүүлэлтээ тохируулдаг тул хугацааны явцад нийт эмзэг бүлгийн өрхийн тоо өөрчлөгдсөн. Нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд эмзэг бүлгийн гэж тодорхойлогдсон хүн амын тоо тэг болж буурсан, гэхдээ БОНХЗ эдгээр бүх ажлуудыг сум Оюу толгойгоос хараат бусаар явуулж байгаа тул, Нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд албан ёсоор аудит хийх хүртэл ОТ-н зүгээс нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан эмзэг бүлгийн өрхүүдэд зориулсан ажлуудын үр дүн, үр өгөөжид хяналт тавьж, үнэлэн, үнэхээр зорьсон үр дүндээ хүрсэн эсэхэд хяналт тавих нь зүйтэйг онцлон тэмдэглэмээр байна.

#### *Оролцогч талуудтай хамтран ажиллах*

ОНХНХ баг Ханбогд болон бусад зорилтот сумдын ард иргэдтэй хэд хэдэн чиглэлээр хамтран ажиллаж байна. Оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө нь оролцогч талуудтай хамтран ажиллах арга замыг тусгасан ерөнхий төлөвлөгөө юм. БОНХЗ төлөвлөгөөнд БОНХЗ/Зээлдүүлэгчийн зүгээс өгөх гол санал зөвлөмжийг тусган 2016 оны 8-р сард хянан шинэчилсэн. Уг Үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөөг 2016 оны 7-р сард Зээлдүүлэгч нар бататгаж, баталсан. Чиглэл тус бүрээр боловсруулсан Оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө нь: Экосистемийн үйлчилгээний чиглэлээр ОТТХАТ, Ундай голын ОТХАТ, ХХБ-ийн ослын үед ОТХАТ, Гүний уурхайн төслийн ОТХАТ болно.

Ханбогд дахь Иргэдийн хөгжлийн төв нь зочид хүлээж авах, иргэдийн оролцоотой уулзалт, арга хэмжээ зохион байгуулахад гол үүрэг гүйцэтгэсээр байгаа бөгөөд өмнөх аудитаас хойш 719 зочин хүлээж авсан байна. ОТ хамтын ажиллагааны бүртгэл мэдээлэлд үндэслэн хамтын ажиллагааны төрөл, оролцогч талуудын бүлэг, тэдний хандлага зэрэгт нарийвчилсан анализ судалгаа хийж байна. Нийт хамтын ажиллагааны 49%-г зөвлөлдөх арга хэмжээ эзэлж байна. Ихэнх нь ОТ-д эерэг хандлагатай байдаг бөгөөд ОТ-д өгсөн санал хүсэлтээс үзэхэд БОХОХШ-ний хөтөлбөрт үнэлгээ хийх гэж байгаа нь нутгийн иргэдтэй хамтран ажиллах тогтолцоо маш идэвхитэй ажиллаж байгааг харуулж байна.

Мэдээлэл өгөх ажлыг мөн нэмэлтээр хийсэн ба нийт орон нутгийн иргэдтэй хийсэн уулзалтын 40%-ийг энэ зорилгоор зохион байгуулсан байна. Ханбогд, Даланзадгадын нээлттэй өдөрлөг (2016 оны 9-р сар, 2017 оны 3-р сард тус тус зохион байгуулсан) зохион байгуулсан нь ажил горьлогчид, гэрээгээр ажиллах боломжтой аж ахуй нэгж болон Өмнөговийн ард иргэдэд илүү өргөн хүрээнд мэдээлэл хүргэх боломж олгосон. Уг арга хэмжээг аймгийн тамгын газрын дэмжлэгтэй зохион байгуулсан ба цаашид жил бүр хамтран зохион байгуулж байхаар болсон.

Иргэдээс ирэх гомдол хүсэлтийг бүртгэсээр байгаа ба өмнөх аудитаас хойш нийт 11 гомдол хүлээж авсан байна. Ирсэн гомдол саналыг ангилж үзвэл: 4 гомдол хүсэлт нь байгаль орчинтой холбоотой байсан бол 7 нь хангамж/гэрээт компанитай холбоотой байсан. Эдгээрээс гадна 2 эерэг санал сэтгэгдэл ирсэн. Хоёр авто осолд хийсэн ОТ-н ослын судалгаанаас үүдэн гомдол хүсэлт барагдуулах тогтолцоог дахин авч үзэх шаардлага гарсан. Уг системд эрсдэлийг үнэлэх сайжруулалт хийсэн. Ийн тасралтгүй сайжруулалт хийгдэж байгаа нь сайшаалтай. Системд оруулсан өөрчлөлтийн үр нөлөөг дараагийн аудитаар шалгах болно. Хүлээж авсан гомдлын талаарх мэдээллийг сар тутмын орон нутгийн сонингоор дамжуулан гадагшаа тогтмол мэдээлэхээс гадна дотоод бүтэц зохион байгуулалтаараа дамжуулан мөн дотоодод мэдээлдэг.

Өмнөх аудитаас хойш Гурван талт зөвлөл хурлаа тогтмол хийсэн бөгөөд Хууль дүрмийн хэрэгжилтийн зөвлөх Омбудсманы газрын тусламжтайгаар Ундай голын гольдролд өөрчлөлт оруулах, нөлөөлөлд өртсөн малчдын нөхөн төлбөртэй холбоотой хоёр гомдлыг барагдуулах чиглэлээр авч хэрэгжүүлэх

нарийвчилсан арга хэмжээг тусгасан Малчдаас ирсэн гомдлыг шийдвэрлэх хоёр гэрээнд 2017 оны 5-р сард гарын үсэг зурсан. Энэ хоёр гэрээ нь үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө, Нөхөн олговрын өргөдлийн хорооны процессыг хэрэгжүүлэх нөхцөл болж өгч байгаа юм. Эдгээр гэрээ байгуулагдсанаар Хууль дүрмийн хэрэгжилтийн зөвлөх Омбудсманы газрын дээрх хоёр гомдлыг шийдвэрлэх явц “Нээлттэй” гэсэн төлвөөс “Хяналтад” гэсэн төлөвт албан ёсоор шилжиж байгаа юм. Энэхүү чухал үе шатанд хүрэхэд хүчин зүтгэл гаргасан бүх талуудыг сайшаах нь зүйтэй. Хууль дүрмийн хэрэгжилтийн зөвлөх Омбудсманы газар дахин нэг жилийн хугацаанд хяналт тавьж, эдгээр гомдлуудыг эцсийн байдлаар хаах эсэхийг тодорхойлно.

Олон талт шинжээчийн баг/хөндлөнгийн шинжээчдийн зөвлөлийн II шатны судалгаа 2017 оны 1-р сард дууссан. Энэ судалгаа зорилгынхоо дагуу ОУСК Хууль дүрмийн хэрэгжилтийн зөвлөх Омбудсманы газарт бүртгэгдсэн хоёр гомдлыг шийдвэрлэх чиглэлээр ГТЗ-ийн хамтарсан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах үндэслэл болох юм. Хамтарсан үйл ажиллагааны төлөвлөгөө нь өмнө дурдсан Гомдол шийдвэрлэх гэрээний хүрээнд багтах юм. ОТШБ-ийн судалгааны үр дүнг энэхүү тайлангийн Нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой хэсэгт дурдсан болно.

#### *Бүс, орон нутгийн хөгжил*

Бүс, орон нутгийн хөгжил нь ОННХ-н багийн болоод 2015 оны 4-р сарын 22-нд байгуулагдан хэрэгжиж буй Хамтын ажиллагааны гэрээний гол чиг үүргүүдийн нэг юм. Хөгжлийг дэмжих сангийн ТУЗ-ийн 2017 оны 3-р сарын хуралд нийт 25 төслийн санал хүлээн авч хэлэлцсэн бөгөөд Харилцааны хорооноос өгсөн зөвлөмжийн дагуу 16-г нь баталсан. ХДС-ийн ТУЗ нийт 2,605,140,405 төгрөг (ойролцоогоор \$1.1 сая ам.доллар)-тэй тэнцэх дүнтэй төслийг баталсан. ХДС-ийн багийнхан “төсөл шалгаруулах” процессын дагуу олон тооны төслийн саналыг удирдахад илүү тохиромжтой шинэ загвар нэвтрүүлж байна. Уг загварын дагуу аймаг хөгжүүлэх мастер төлөвлөгөөний стратегийн тэргүүний ач холбогдол бүхий чиглэлүүдтэй уялдуулан жилд хоёр удаа төслийн саналуудыг авч үзэх юм. БОНХЗ-ийн зүгээс төслийн саналуудыг илүү сайн удирдах, батлагдсан төслүүдэд үр дүнтэй хяналт тавих боломжийг ХДС-д олгох арга хэмжээг дэмжиж байгаа бөгөөд дараагийн аудитаар энэ чиглэлээр хийгдсэн ажлуудыг шалгахын зэрэгцээ ХДС-ийн эхний жилийн тайлангийн (2017 оны 6-р сард гарах) үр дүнгүүдтэй танилцах болно.

Хаан банк бичил зээл олгох чиглэлээр Говийн Оюу ТББ-тай хамтран ажиллахаар шалгарсан. 2017 оны 2-р сарын 1-с 3-р сарын 20-ны хооронд хүлээн авсан зээлийн хүсэлтийн 75% нь дэмжигдсэн. Бичил зээлийн санхүүжилтээр хэрэгжиж буй бизнес /үйл ажиллагааг дурдвал: хүлэмжийн аж ахуй, оёдлын үйлчилгээ, авто засвар үйлчилгээ, гоо сайхны салон, торт, нарийн боов үйлдвэрлэл зэрэг болно. Нэг төсөлд дээд тал нь 30 сая төгрөгийн хэмжээтэй зээл олгож байна.

ОТ-Азийн хөгжлийн банкны (АХБ) хамтарсан санхүүжилтээр Ханбогдын үс хангамжийн төсөл 12-р сард эхэлсэн бөгөөд тус сумын 13,000 оршин суугчдыг цэвэр/ундны усаар хангаж байна. Цаашид шаардлага гарвал 32,000 оршин суугчдыг усаар хангах хүчин чадалтай. БОНХЗ Ханбогд суманд энэхүү чухал ач холбогдолтой төслийг хэрэгжүүлэхэд оролцсон талуудад талархал илэрхийлье. Үүний үр дүнд Ханбогд сум Монгол улсад ус хангамж, ариутгах татуургын системтэй цорын ганц сум болж байна. Орон нутагт хэрэгжиж буй бусад дэд бүтцийн ажлуудын хувьд ОТ-Гашуунсухайтын замын төсөл одоогоор санхүүжилтийг хянаж үзэх, батлах, төслийн санхүүжилтээс хамаарч гэрээт компанийг сонгохтой холбоотойгоор түр зогсоод байна. Харин ОТ-Ханбогдын чиглэлийн автозам 2018 оны 10-р сард бодит гүйцэтгэлдээ хүрэх төлөвлөгөөний дагуу үргэлжилж байна.

Өмнөх аудитаас хойш ОТ Хүн амын шилжин ирэх хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөг хянан үзэж одоогийн Хүн амын шилжилт хөдөлгөөний менежментийн төлөвлөгөөг эцсийн байдлаар гаргасан. Зээлдүүлэгч нар нэмэлт өөрчлөлт оруулсан ХАШХМТ-г баталсан. Тус төлөвлөгөөнд Өмнийн говийн Удирдах хороонд ОТ төлөөллийн гүйцэтгэж байсан үүрэг, үйл ажиллагаа зэрэг ОТ-н удирдлагын зүгээс хүлээх үүрэг хариуцлагыг албажуулсан. ОТ саяхан байгуулагдсан Харилцааны хороонд дэмжлэг үзүүлж ажиллах ёстой хэвээрээ бөгөөд энэ үйл ажиллагааг ил тод явуулж, олон нийтэд мэдээлэх ёстой. ОТ хэд хэдэн арга хэрэгслийг ашиглан Ханбогдын хүн амзүйн өөрчлөлтийн судалгаа (өмнөх аудитын үеэр хүн амын шилжин ирэх хөдөлгөөнийг түр зогсоосон үеийг оруулсан) хийсэн. Судалгаанд хүн амын албан

болон албан бус тоо мэдээ цуглуулж, гол мэдээлэгчтэй нартай ярилцлага хийж, ГМС болон сансрын зураглал ашиглан геодезийн гурван хэмжээст зураг үүсгэх аргачлал ашигласан. ОТ болон сүм орон нутагт үр өгөөжөө өгөх үг хяналт-шинжилгээг хийхэд хэд хэдэн төрлийн аргачлал ашигласан нь сайшаалтай хэрэг гэж үзэж байна.

Өмнийн говийн Удирдах зөвлөлийг өргөжүүлж, дахин зохион байгуулалтад оруулж, Харилцааны хороо шинээр байгуулсан нь хамтын ажиллагаа, хүн амын шилжин ирэх хөдөлгөөнийг удирдах асуудалд чухал үүрэг гүйцэтгэж байна. Харилцааны хороо нь ОТ, Өмнөговь аймгийн тамгын газар, сумын тамгын газрын төлөөлөөс бүрддэг бөгөөд бүх талуудын хүчин чармайлтыг оновчтой зохицуулахыг эрмэлзэж байна. БОНХЗ дараагийн аудитаар тус Хорооны одоогийн хийж буй ажлын хэрэгжилтэд хяналт тавьж, тус хорооны зүгээс 2017 оны 4-р улирал гэхэд боловсруулан гаргахаар төлөвлөсөн Өмнийн говийн урт хугацааны стратегитай танилцах болно. Дээрх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн тул Хүн амын шилжин ирэх хөдөлгөөний менежментийн төлөвлөгөөтэй холбогдох зөрчлийг хаасанд тооцов.

#### **Ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа**

Эрүүл мэндийн баг нь ЭМААБОАБОН-ийн хэлтэст харьяалагддаг төвлөрсөн нэгж бөгөөд хөдөлмөрийн эрүүл мэндийн үйлчилгээ, олон улсын SOS эмнэлгийн үйлчилгээг хамааруулан ажилладаг. Ажлын байран дахь эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээнд өндөр эрсдэлтэй хэсэгт ажилладаг ажилтнуудын дуу чимээ, тоос, тоосонцор, силикос, гагнуурын очид өртөх өртөлтийн хэмжээнд анхаарч ажилладаг. Үнэлгээ хийж, сайжруулах арга хэмжээ авахаас гадна ажилтнуудад эрүүл мэндийн эрсдэлийн талаарх ойлголт мэдлэгийг нь дээшлүүлэх сургалтууд явуулж байна. 2017 онд Эрүүл мэндийн баг сэтгэцийн эрүүл мэнд, эрүүл амьдралын хэв маягийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн.

Гүний уурхайн төслийн үйл ажиллагаа жигдэрснээр энэ жил гэхэд нийт 3,500 ажилтан шинээр нэмэгдсэн бөгөөд тэдний олонхи нь ОТ-н аюулгүй ажиллагааны хөтөлбөр, гүний уурхайн барилгын ажлын талаар туршлага багатай. Одоо хэрэгжиж буй аюулгүй ажиллагааны хөтөлбөрүүд нь гэрээт компанийн ажилтнуудын хамт ОТ ажилтнуудын өсөлтийг удирдахад тохирсон эсэхийг нягтлахын зэрэгцээ ОТ хамтын ажиллагаанд аюулгүй ажиллагааг дэмжих зорилгоор Жишиг соёл хөтөлбөрийг санаачилаад байна. Уурхайн ажилтнуудад учирч болох 17 ноцтой эрсдэлд онцгойлон анхаарч, ноцтой эрсдэлийн хяналтын магадлагаа хийх зорилготой Ноцтой эрсдэлийн менежментийн хөтөлбөрийг уурхай даяар хэрэгжүүлж, гүний уурхайн үйл ажиллагаа болон гэрээт компаниудын үйл ажиллагаанд нэвтрүүллээ. Тус хөтөлбөрийг удирдлага, ажилтнуудын дунд илүү сайн хэвшүүлэх зорилгоор ноцтой эрсдэлийн хяналтын чанарын магадалгаа хийхэд ач холбогдол өгч ажиллаж байна. Химийн бодис алдагдах, гал гарах, дэлбэрэлт үүсэх, бусад аюул осол зэрэг үйлдвэрийн үйл ажиллагааны системээс үүдэлтэй болзошгүй аюул эрсдэлийг авч үзэх Үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны менежментийн системийг Баяжуулах үйлдвэр, Төв дулааны станц, Максам тэсэлгээний байгууламжид нэвтрүүлсэн. Ил уурхай, Хаягдал хадгалах байгууламж, Экспортын тээвэрлэлтийн хэлтсүүдийн тээврийн автомашины операторуудын алжаал ядаргааг удирдах, мөн хэд хэдэн хэлтэст хамаарах гараар гүйцэтгэх зайлшгүй шаардлагатай ажил үүргийг тодорхойлж, сайжруулах төлөвлөгөө боловсруулах зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаа талаар Эрүүл мэндийн хэлтэс онцлон тэмдэглэсэн.

#### **Нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал**

Эрүүл малчин хөтөлбөр зэрэг нутгийн иргэдийн эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөрүүд үргэлжлэн хэрэгжиж байна. Бүх тоног төхөөрөмжийг төлөвлөсний дагуу худалдан авч, хөдөөгийн болон Ханбогд суман дахь малчид, сумын төв дэх иргэдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажил эхэлсэн. Эрүүл мэндийн үзлэг эхний ээлжинд нийт 1,139 иргэн хамрагдсан байна (2016 оны 10-р сарын байдлаар).

Ханбогд дахь хүүхэд залуусын клиник 2017 оны 1-р сард 10-17 насны нийт 450 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийсэн байна. Тус клиник нь Ханбогд сумын эмнэлэгт байрладаг бөгөөд тус суманд залуусын оролцоог нэмэгдүүлэх, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах зэрэг тус сумын залууст чиглэсэн нэмэлт хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг.

ОТ энэ аудитын хугацаанд нутгийн иргэдийн аюулгүй байдалтай холбоотой ямар нэгэн зөрчил, асуудал гараагүй гэж мэдэгдсэн. ОТ гэмт хэргийн статистик мэдээллийг хянаж байгаа бөгөөд Цагаан хадан дахь нүүрсний тээвэр, автозамын хөдөлгөөнтэй холбоотой цөөн тооны эрүүгийн хэргийн тохиолдол гарсан байна. ОТ цаашид болзошгүй эрсдэл, гэмт хэргийн асуудлаар, тэр дундаа хил орчимд, Өвөр Монголын Өөртөө Засах оронд байгуулах гэж буй ОТ-н оффисын үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй асуудлаар Цагдаагийн газар, Ханбогд дахь сумын бусад эрх бүхий байгууллагуудтай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэх нь зүйтэй. Ханбогдын эрх бүхий байгууллагуудтай идэвхитэй хамтран ажилласнаар ОТ-Ханбогдын автозамын барилгын ажилчдын байрлаж буй Зуны кэмпэд гарч болзошгүй хэрэг зөрчлийг үр дүнтэй хязгаарласан бөгөөд кэмптэй холбоотой үүсч болзошгүй нийгмийн аливаа сөрөг асуудлыг бууруулах зорилгоор уг талбайг удирдан зохицуулж ажилласан багийнхны зүтгэлийг сайшаах нь зүйтэй.

Хаягдал хадгалах байгууламжийн онцгой байдлын үед авах арга хэмжээний журам боловсруулах ажил үргэлжилж байна. Нутгийн ард иргэд болон орон нутгийн засаг захиргааны хувьд тус сэдэвт мэдрэг ханддаг байдлыг харгалзан үзэж ослын мэдэгдэл хийх процессыг боловсруулах тал дээр орон нутгийн холбогдох алба, нутгийн иргэдтэй хамтран ажиллаж байна. Осолд өртөж болзошгүй хэсэг дэх малчин өрхүүдтэй холбоо барих мэдээллийг тогтмол шинэчилж, ХХБ-ийн Ослын бэлэн байдлын хамтын ажиллагааны төлөвлөгөөний төсөл боловсруулахад тэдэнтэй хамтран ажиллаж байна. Ослын хариу арга хэмжээний албан ёсны төлөвлөгөөг Ханбогдын Онцгой байдлын хороогоор дамжуулан сумын тамгын газарт хүргүүлсэн. Энэ сэдвээр хэлэлцээр хийх нь ярвигтай бөгөөд цаг хугацаа шаардсан үйл явц гэдгийг БОНХЗ хүлээн зөвшөөрч байна.

ХХБ-ийн онцгой байдлын журамд улирлын чанартай суурьшдаг нөлөөнд өртөж болзошгүй малчин өрхийн (өөрөөр хэлбэл осолд өртөж болзошгүй бүсэд өвөлжөөтэй айлууд) бүртгэлийг тусгаж өгсөн. ХХБ-ийн Нутгийн иргэд, оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөөг 2017 оны сүүлээр эцэслэн гаргах бөгөөд үүнд ослын бэлэн байдал хангах арга хэмжээ, болон ОТ-н ослын үед хариу арга хэмжээ авах хөтөлбөрийн талаар хамрагдах бүсийн орон нутгийн холбогдох албаны хүмүүс болоод ослын нөлөөлөлд өртөх иргэд, оршин суугчдад мэдлэг мэдээлэл өгөх алхамуудыг тусгасан. БОНХЗ дараагийн аудитаар өрхүүдийн мэдээллийг авч холбогдох хамтын ажиллагааны арга хэмжээнүүдийн талаар дэлгэрэнгүй хэлэлцэнэ гэж төлөвлөж байна.

#### ***Соёлын өвийн менежмент***

ОТ-н Соёлын өвийн менежментийн төлөвлөгөө (СӨМТ) хэрэгжиж байгаа бөгөөд соёлын өвтэй холбоотой ямар нэг зөрчил бүртгэгдээгүй. Соёлын өвийн менежментийн систем (СӨМС)-ийн хэрэгжилтийн хүрээнд аудитын хугацаанд орон нутгийн иргэдэд мэдээлэл өгөх үүлзалт, соёлын өвтэй холбоотой чиглүүлэх сургалт нийт 830 удаа хийж, газар хөндөх 60 зөвшөөрөл олгосон байна.

Соёлын өвийн хяналт-шинжилгээг Чог агуй, Хүрдэт агуй, ОТ-Ханбогд чиглэлийн автозам, Шар цав, Мэлхий цохио, Дэмчогийн хийд гэсэн зургаан газар хийж байна. Монгол улсад шинээр хэрэгжиж эхэлсэн хуулийн дагуу эдгээр газрын ихэнх нь соёлын өвийг сахин хамгаалагчдын (нутгийн малчид) хамгаалалтад байдаг бөгөөд эдгээр үүрэгтнүүдэд аймгийн Боловсролын хэлтэсээс сургалт зохион байгуулдаг.

Шар цав, Хүрдэт агуйг хамгаалах ажлуудыг ХДС-ийн санхүүжилтээр санхүүжүүлэх ажил ахицтай үргэлжилж байна. Шар цавд мэдээллийн төв, явган хүний зам, үлэг гүрвэлийн мөрийг ажиглах шат зэргийг байгуулсан бол Хүрдэт агуйд хамгаалалтын хашаа, мэдээллийн самбар барьж, эхний шатны ажлуудыг дүүсгаад байна. 2017 оны 6-р сараас нэмэлт хамгаалах арга хэмжээ авч, тэмдэг тэмдэглэгээ суурилуулна. Эдгээр хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэхээр ОТ болон ХДС хамтран ажиллаж буй нь сайшаалтай.

## 1 УДИРТГАЛ

Оюу толгой төсөл нь (цаашид “Төсөл” буюу “ОТ Төсөл” гэх) Монгол улсын өмнийн говийн бүс нутаг Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт, нийслэл Улаанбаатар хотоос өмнө зүгт ойролцоогоор 600 км, Монгол-Хятадын хилээс хойд зүгт 80 км-т оршдог. Тус ашигт малтмалын ордыг 2001 онд нээж илрүүлсэн бөгөөд зэс, алт, мөнгө, бага хэмжээний молибден агуулсан хэд хэдэн бүлэг ордноос бүрдэнэ. Тус төсөл нь Ил уурхай, Гүний уурхайг хамрах бөгөөд Баяжуулах үйлдвэр өдөрт 100,000 тонн баяжмал боловсруулан гаргаж, жилд 500,000 гаруй тонн баяжмал үйлдвэрлэнэ гэж тооцоолж байна. 2013 оны 7-р сараас хэрэглэгч нартаа бүтээгдэхүүнээ тээвэрлэн хүргэж эхэлсэн.

2013 оны 9-р сард “Оюу толгой” ХХК (цаашид “Төслийн компани” буюу ОТ гэнэ) өөрийн хэрэгжүүлж буй Оюу толгой төслийн (Монгол улс засгийн газар, Рио Тинто групп (цаашид РТ гэнэ), Туркуойз Хилл Ресурс компани хоорондын стратегийн түншлэл) Байгаль орчин, нийгмийн хөндлөнгийн зөвлөхөөр (БОНХЗ<sup>6</sup>) Итали улсын Генуя хотод байрладаг Д'Апполониа ХК (2017 оны 6-р сарын 5-с эхлэн АрАйЭнЭй Консалтинг болсон)-ийг ажиллуулахаар гэрээ байгуулсан. 2012 оноос эхлэн РТ групп нь төслийн бүх хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдыг төлөөлөн төслийн менежментийг хариуцахаар томилогдсон.

АрАйЭнЭй Консалтинг компани БОНХЗ-ийн хувьд санхүүжүүлэгч байгууллагуудад зориулан 2013 оны 9-р сарын 1-нд эхэлсэн ОТ уурхайн ашиглалтын (Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин) ЭМААБО, нийгмийн чиглэлд гол анхаарлаа хандуулан хөндлөнгийн үнэлгээ хийж гүйцэтгэх үүрэгтэй. БОНХЗ нь уг үүргийнхээ хүрээнд ОТ төсөл Үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөөндөө тусгасан байгаль орчин, нийгмийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлж байгаа эсэхийг санхүүжүүлэгч байгууллагуудад тайлагнах бөгөөд уг төлөвлөгөө нь БОННУ болон бусад холбогдох бичиг баримтад тодорхойлсон нөлөөллийг бууруулах стратегийг ОТ компани хэрхэн хэрэгжүүлэхийг заасан баримт бичиг юм. Эдгээр нь ирээдүйд тодорхой цаг хугацаатай гүйцэтгэх үйл ажиллагааны жагсаалт, мөн БОНХЗ төслийн Байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны (БОНЭМАА) гүйцэтгэлд хяналт шинжилгээ хийхдээ ашигласан лавлагаа баримт бичиг болсон Ашиглалтын БОНМТ-үүдийг агуулсан төслийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ), Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө (БОНУАТ) болно.

Энэхүү тайланд уурхайд ажиллах үеэр ажиглалт хийн, төслөөс ирүүлсэн тайлан баримт бичгүүд, судалгаа, танилцуулгатай танилцаж, мөн уурхайн ажилтнуудтай ярилцсаны үндсэн дээр Төсөл эрүүл мэнд, байгаль орчин, аюулгүй ажиллагаа, нийгмийн чиглэлээр хүлээсэн үүрэг амлалтаа хэрхэн биелүүлж, дагаж мөрдөж байгаа талаар авсан ойлголт, өгсөн үнэлгээгээ тусгалаа. Энэ тайланд зөвлөхийн 2017 оны 5-р сард уурхайд очиж ажиллах үеийн Төслийн нөхцөл байдлыг тусгасан болно. Төсөл Үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөөнд тусгасан амлалт үүргүүдээ хэрхэн биелүүлж байгааг үнэлэхэд гол анхаарлаа хандуулахаас гадна өмнөх аудитаар илрүүлсэн, төслийн өнөөгийн үйл ажиллагаанд нөлөөтэй хэвээр байж болох зарим зөрчлүүдэд мөн үнэлгээ өглөө.

Дараах тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүнд:

- ОТ компанийн өгсөн БОЭМАА, нийгмийн баримт бичиг, төсөлтэй холбоотой бусад баримт бичигтэй урьдчилан танилцаж судлах;
- Уурхайн талбайд ажиллаж, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны болон нийгмийн шаардлагуудын хэрэгжилтэд газар дээр нь хяналт тавих
- ЭМААБО, нийгмийн чиглэлийн дүрэм, журмын биелэлтийг хариуцсан төслийн багуудтай уулзаж, холбогдох төлөвлөгөө, журамтай танилцаж;

<sup>6</sup> БОНХЗ багийн гишүүд: **Жиованни Ди Франчи** (Төслийн менежер, багийн ахлагч – Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны мэргэжилтэн), **Роберт Сноу** (Ахлах хянагч – Уурхайн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны мэргэжилтэн), **Дана Стренг** (Байгаль орчин, гидрологийн мэргэжилтэн), **Анжела Рийман** (Нийгмийн харилцаа, орон нутгийн харилцааны асуудал хариуцсан мэргэжилтэн), **Жоана Трийвик** (Биологийн олон янз байдлын мэргэжилтэн)

- Үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөө болон БОНМХ-т тодорхойлсон үүрэг хариуцлагын хэрэгжилт, биелэлтэд үнэлгээ хийх;
- Үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөө болон БОНМХ-т тодорхойлсон үүрэг хариуцлагаас гажсан буюу аль эсвэл зөрүүтэй, дутагдалтай зүйл байгаа эсэхийг тодорхойлж, Салбарын олон улсын тэргүүн туршлагад (СОУТТ) үндэслэн БОЭМАА-г сайжруулах чиглэлээр зөвлөмж өгөх;
- БОНХЗ-ийн 2016 оны 8-р сард хийсэн Аудитын тайланд<sup>7</sup> тодорхойлсон дүгнэлт, ажиглалтын мөрөөр гүйцэтгэлийг хянаж, арилсан зөрчлийг хаах.
- БОНХЗ-ийн тайланг (энэ тайлан) боловсруулж, олон нийтийн хүртээл болгох.

ОТ уурхай дахь оффист 5-р сарын 25-нд дүнгийн хурал хийж, уурхайд ажиллах үеэр хийсэн ажиглалтын үр дүнг танилцуулж, аудитын дүгнэлтийг урьдчилсан байдлаар танилцуулсан нь энэ тайлангийн үндэслэл болсон.

Энэхүү тайланд дурдсан мэдээлэл, ажиглалт, үзэл бодол нь АрАЙЭНЭЙ Консалтинг компанийнх бөгөөд тэдгээр нь Төсөл болон/эсвэл давуу эрхтэй Зээлдүүлэгчдээс хараат бус, бие даасан болно. Тайланд дурдагдаагүй сэдвүүдийн тухайд ямар нэг эрсдэлтэй зүйл төслийн хүрээнд илрээгүй болно.

---

<sup>7</sup> Д'Апполониа “Байгаль орчин, нийгмийн хууль, дүрмийн хэрэгжилтийн хөндлөнгийн хяналтын тайлан – 2016 оны 8-р сард уурхайд ажилласан тайлан, 2016 оны 10-р сар, Баримт бичгийн дугаар 13-391-Н9”

## 2 ТӨСЛИЙН ТОЙМ

### 2.1 БАРИЛГА, АШИГЛАЛТЫН ЯВЦ

Уг төсөл нь зэс, алт, мөнгө, молибдены хэд хэдэн ордоос бүрдэх ба далд болон ил уурхайн арга техникийг хослуулан олборлодог. Төслийн ашиглалтын хугацаа нь Баттай ба Бодитой нөөцөд суурилснаар 40 жил (2016 оноос хойш) байна. Өмнөд Оюу орд болон Хюго Даммит орд нь хамтдаа 25.4 сая тонн зэс, 81,600 тонн молибден, ойролцоогоор 5,150 тонн мөнгө, 1,000 тонн алтны нөөцтэй гэж одоогийн байдлаар тогтоогоод байна. Өмнөд Оюу ордод зэс, алтны Ил уурхай, мөн Гүний уурхай (Хюго Даммит орд) байгуулж олборлолт хийхээр төлөвлөж байна. Баяжуулах үйлдвэрийн анхны зураг төслийн дагуу жилд 35 сая тонн түүхий хүдэр олборлох тооцоонд үндэслэн боловсруулагдсан (нэрлэсэн хүчин чадал нь өдөрт 100,000 тонн) ба жилд 500,000 гаруй тонн баяжмал боловсруулж гаргана гэж тооцоолж байна.

Ил уурхайгаас 2012 оны 2-р улиралд хоногт 24 цаг тасралтгүй энгийн хүнд даацын машин болон экскаватор ашиглан олборлож эхэлсэн. Тус уурхай нь ил уурхайн дотор талын налуу, хэвгийг тогтворжуулахын тулд чулуугаар хашиж тэсэлгээ хийсэн хэд хэдэн мөргөцгөөс бүрдэх ба хүдэр болон хаягдал шороо, чулууг хүнд даацын машинаар зөөхийн тулд тээврийн зам гаргасан байна.

Гүний уурхайг блокчлон олборлох аргаар олборлохоор төлөвлөж байгаа ба хүдрийн дор тулгуур үлдээн малтлага хийснээр хүдэр нь хүндийн хүчний үйлчлэлээр малтлага хийсэн хоосон орон зай руу өөрөө нурж орох замаар олборлоно. Гүний уурхайгаар олборлох арга нь үр ашигтай, өртөг зардал багатайгаас гадна хаягдал шороо чулуу бага гардаг, том хэмжээний хүдрийн биет олборлох боломжтой юм.

Хүдрийг баяжмалд хувиргах процессын загварыг энгийн бутлах, хөвүүлэн баяжуулах технологи болон батлагдаж туршигдсан тоног төхөөрөмж ашиглахад үндэслэн гаргасан. Тус процесст том бутлагдсан хүдрийг овоолж, анхдагч бутлуураар бутлах үйл ажиллагаа орно. Анхдагч бутлуураар буталсан хүдрийг 2.7 км урт газрын гадаргуу дээрх туузан дамжуулагчаар баяжуулах үйлдвэрийн ойролцоо байрлах овоолго руу хүргэж, тэндээсээ хүдрийг жижигсгэн бутлах том диаметртэй цувраа тээрэм рүү шилжүүлнэ. Хөвүүлэн баяжуулах систем нь зэс агуулсан материалыг дараагийн үе шатанд боловсруулахаар шүүн авах ба флотацын том бассейн дотор шаардлага хангахгүй эрдсийг үнэ цэнэтэй хүдрээс ялгаж авдаг. Энэ зуур лагийг (хаягдал) хоёр өтгөрүүлэгчид 60% хатуу болгож өтгөрүүлээд, Хаягдал хадгалах байгууламжид (ХХБ) шахаж зайлуулдаг. Хаягдал өтгөрүүлэгч болон ХХБ-аас гарсан усыг баяжмал үйлдвэрлэхэд дахин ашиглана. Үүний дараа зэс, алт агуулсан эцсийн бүтээгдэхүүн болох баяжмалыг өтгөрүүлж шүүгээд битүүмжилсэн уутанд хийж савлан, ачааны машинаар Хятад улс руу Гашуун Сүхайт/Ганц модны боомтоор дамжуулан тээвэрлэнэ.

Уурхайн үйл ажиллагааны нэмэлт туслах байгууламжид орон нутгийн онгоцны буудал, Хятад улсын хойд хэсэгт орших Өвөр Монголын цахилгаан эрчим хүчний сүлжээнээс өндөр хүчдэлийн шугамаар дамжуулан авах 220 киловаттын (кВ) цахилгаан дамжуулах шугам, нүүрсээр галладаг дулааны төв станц (ДТС), үс хангамж, бохир ус цэвэрлэх байгууламж, засварын цех, агуулах, захиргааны байр, хог хаягдлын байгууламж, түлш хадгалах депо, захиргааны байр, орон сууц, авто зам, тээврийн байгууламж зэрэг орно.

Төсөл 2013 онд ил уурхайгаас олборлолт явуулж эхэлснээр ашиглалтын үе шат нь эхэлсэн. Үүнээс хойш Баяжуулах үйлдвэрээс гарах бүтээгдэхүүний хэмжээ тогтмол өсч, баяжмалыг Хятадын зах дээлд гаргаж байна. 2015 он ОТ-н хувьд бүтэн үйлдвэрлэл явуулсан хоёр дахь жил байсан бөгөөд уурхайн олборлолтын үзүүлэлтээр шинэ амжилт тогтоосон юм. Баяжуулах үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг жилийн туршид хэрэгжүүлснээр оны эцэст үйлдвэр тооцоот хүчин чадалдаа хүрч ажилласан. 2016 онд 201,300 тонн зэс, 300,000 унци алт үйлдвэрлэсэн. 2017 оны эхний улиралд баяжруулах үйлдвэр өдөрт дундажаар 112,100 тонн баяжмал үйлдвэрлэсэн дээд амжилт тогтоосон. Гэхдээ ОТ 2017 онд 130,000 – 160,000 тонн зэсийн баяжмал, 100,000 – 140,000 унци алтны баяжмал үйлдвэрлэх тооцоотой байна. Үйлдвэрлэл 2016 онтой харьцуулахад буурсан нь үндсэндээ Ил уурхайн одоогийн олборлолт хийж буй хэсгийн зэсийн агуулга нь хорин таван хувиар бага, алтны агуулга нь бараг тавин хувиар бага байгаатай холбоотой.



2013 онд түр зогсолт хийсний дараа Гүний уурхайн үйл ажиллагаа 2016 онд Гүний уурхайн төслийг үргэлжлүүлэх хөтөлбөрийн дагуу дахин эхэлж, 2017 онд Гүний уурхайн 2-р шатанд шаардлагатай нөөц, хүн хүчээ бүрдүүлж эхэлсэн. Хөндлөн нэвтрэлт, уурхайн дэд бүтэц, хүдрийн биетэд хүрэх тоног төхөөрөмж, туузан дамжуулагчийн барилга угсралтын ажлууд бүгд чанарын түвшинд, аюулгүй ахиж урагшилж байна. Олон улсын гэрээт компаниудтай түншилсэн орон нутгийн компаниуд төсөлд хувь нэмрээ оруулж байна. Гүний уурхайн бүтээн байгуулалт, хонгил байгуулах ажлууд дуусмагц уурхайн төлөвлөгөөний дагуу 2020 оноос эхлэн ил уурхайн биетээс гүний уурхайн агуулга өндөртэй биетэд олборлолт хийж эхэлснээр зэсийн үйлдвэрлэл үлэмж хэмжээгээр нэмэгдэнэ.

БОНХЗ 2017 оны 5-р сард уурхайд ажиллах үед гүний уурхайд туузан дамжуулагчийг газрын гадаргаас доош ахиулан барих, хөндлөн малталт хийх, Босоо ам 2-ыг уурхайн байгууламжуудтай холбож, агаар сэлгэлтийг сайжруулах, хоёрдогч гарц болгож ашиглах, анхдагч бутлуурын барилгын ажлыг эхлүүлэх, гүний уурхайн тэсрэх бодисын агуулах, цех барих, газраас дэмжлэг үзүүлэх элементүүдийг үргэжлүүлэн суурилуулах, уурхайн бусад дэд бүтцийг шинэчлэх, сайжруулах, гүний уурхайн ажиллах хүчинд сургалт явуулах, үр чадварыг нь хөгжүүлэх зэрэг ажлууд хийгдэж байсан.

Нүүрсээр галладаг Дулаан төв станцын үйл ажиллагааг сайжруулах, баяжуулах үйлдвэрийн хүчин чадлыг өдөрт 100 мянган тонноос дээш баяжмал үйлдвэрлэх хүчин чадалтай болгож өргөтгөхтэй холбоотой ямар нэгэн шийдвэр гараагүй байна. БОНУАТ-нд тусгасны дагуу эдгээрт хоёуланд нь байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийлгэх ёстой юм.

## 2.2 ТАЙЛАНГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Энэхүү тайланг дараах байдлаар бүлэг болгон зохион байгуулав:

- 3-р бүлэг – Зөрчлийн хүснэгт;
- 4-р бүлэг – Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, нийгмийн хариуцлагын менежментийн тогтолцоо;
- 5-р бүлэг – Байгаль орчин;
- 6-р бүлэг – Нийгэм;
- 7-р бүлэг – Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа;
- 8-р бүлэг – Соёлын өв.

БОНХЗ-ийн хяналт шалгалтаар илэрсэн үндсэн үр дүнг ажиглалт, тайлбар, зөвлөмж хэлбэрээр энэхүү тайланд тусгасан болно. Хоёр төрлийн үр дүнг багтаасан. Үүнд:

- Үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөө ба/эсвэл СОУТТ-д тодорхойлсон Төслийн үүрэг амлалттай холбоотойгоор Илэрсэн зөрчлийн хураангуйлсан хүснэгт (3-р хэсэг) -д харуулсан зөрчлүүд;
- БОНХЗ-ийн багийн гишүүдийн хамтын мэдлэг, туршлагад үндэслэн тодорхойлж, хэсэг болгоны (4-8) төгсгөлд тусгасан, цаашид авах шаардлагатай арга хэмжээ, нээлттэй асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөсөн санал зөвлөмжүүд.

БОНХЗ-ийн өгсөн зөвлөмжүүд нь заавал биелүүлэх шаардлага биш тул тэдгээрийг нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлага тавигдахгүй. Гэсэн хэдий ч БОНХЗ-ийн өгч байгаа бүх зөвлөмжийг ашигтай, ач холбогдолтой талаас нь харж, хэрэв техник эдийн засгийн талаасаа тохиромжтой бол менежментийн цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг Төслөөс хүсэж байна.

### 3 ЗӨРЧЛИЙН ХҮСНЭГТ

Энэ бүлэгт төслийн талбай дээр очиж ажиллах, ОТ төслийн ажилтнуудтай уулзаж ярилцах үеэр ажиглагдсан зүйлс, талбайд ажиллах үед болон хожим бидэнд өгсөн баримт бичигт үндэслэн, мөн бидний ажлын удирдамжтай нийцүүлэн тус тайланд дэвшүүлсэн зөрчил дутагдлыг хүснэгтээр хураангуйлсан болно.

Тухайн зөрчил дутагдал нь YAMT, БОНМХ, ОТ төслийн хяналт шинжилгээний баримт бичиг, журамд тодорхойлсон ОТ төслийн байгаль орчин, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагын хувьд хэр ноцтой болохыг тодорхойлох, ОТ төслийн ашиглалтын үйл ажиллагаа нь зээлдүүлэгч байгууллагуудын Байгаль Орчин, Нийгмийн холбогдох шалгуурт хэрхэн нийцэж буйг тодорхойлохын тулд хүснэгтийг өнгөөр кодлон ангилсан болно. Өнгөөр кодолсон ангиллыг РТ-ийн ЭМААБООН Менежментийн Системийн ангиллын дагуух ОТ төслийн БОНМТ-нд<sup>8</sup> тодорхойлсон зөрчил дутагдлын ижил түвшинд үндэслэн оноосон юм.

Дараах байдлаар тайлбарлав:

- **IV ангилал** - Төслийн стандарт эсвэл Менежментийн төлөвлөгөөг ноцтой зөрчсөн бөгөөд экологийн эсвэл нийгмийн чухал нөөц, эмзэг хүлээн авагчдад нөхөж баршгүй нөлөөлөл эсвэл ихээхэн хор хохирол учруулсан буюу учруулж болзошгүй эсвэл эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны ноцтой осол эндэгдэл учруулж болзошгүй маш ноцтой зөрчил.
- **III ангилал** - Төслийн стандарт эсвэл Менежментийн төлөвлөгөөг ноцтой зөрчсөн бөгөөд экологийн эсвэл нийгмийн чухал нөөц, эмзэг хүлээн авагчдад нөхөж баршгүй нөлөөлөл эсвэл ихээхэн хор хохирол учруулах эсвэл эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны ноцтой осол эндэгдэл учруулах нь тодорхой илрээгүй хэдий ч тийм үр нөлөө үзүүлж болзошгүй бодитой зөрчил.
- **II ангилал** - Төслийн стандарт эсвэл Менежментийн төлөвлөгөөг зөрчсөн хэдий ч экологийн эсвэл нийгмийн чухал нөөц, эмзэг хүлээн авагчдад нөхөж баршгүй нөлөөлөл эсвэл ихээхэн хор хохирол учруулах хэмжээний биш, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны ноцтой осол эндэгдэл учруулахааргүй бодитой зөрчил.
- **I ангилал** - Төслийн стандарт эсвэл Менежментийн төлөвлөгөөг бүрэн дагаж мөрдөөгүй бөгөөд байгаль орчин, орон нутгийн ард иргэд эсвэл ажилчдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд нөлөөл үзүүлэх магадлал байхгүй.

Хэрэгжүүлэх арга хэмжээг үүрэг даалгаврын дугаараар ангилсан ба (үүрэг даалгаварын Х.Ү дугаар) энд Х нь үүрэг даалгаврын дугаар, Y нь хэрэгжүүлэх холбогдох арга хэмжээний дугаарыг илтгэж байна. Заавар зөвлөмжийг тодорхойлсон текстийг нэг аудитаас нөгөө аудитын хооронд тухайн үеийн нөхцөл байдлыг илүү тодорхой тусгаж өгөхийн тулд хянаж засвар оруулах шаардлагатай гэдгийг цохон тэмдэглэх хэрэгтэй. Гэхдээ анхны дугаарууд нэг ижил үндсэн асуудалд хамаарч байгаа учраас тухайн асуудлыг шийдвэрлэж хаах хүртэл хэвээр үлдээлээ.

Хүснэгтэд тодорхойлсон төсөлтэй холбоотой зөрчил тус бүрт ОТ ямар нэгэн арга хэмжээ авах шаардлагатай бөгөөд БОНХЗ дараагийн удаа ажиллахдаа биелэлтийг нь шалгана. Хүснэгтэд мөн илрүүлсэн зүйлсийн тодорхойлолт, оноосон зөрчлийн түвшин, Төслийн хүлээсэн үүрэг хариуцлагад хамаарч буй холбогдох баримт бичиг, мөн БОНХЗ-ийн хамтын мэдлэг туршлага дээр үндэслэн өгч буй засаж залруулах буюу сайжруулах талаар өгсөн зөвлөмжүүд багтаж байна. БОНХЗ-ийн үзэж байгаагаар зөрчлийг хангалттай хэмжээнд шийдвэрлээгүй тохиолдолд, нөхцөл байдлаас шалтгаалаад бодит үр дагавраас үл хамааран зөрчлийн ангилал нэмэгдэж болзошгүй гэдгийг санах хэрэгтэй ба ямар нэгэн засаж залруулах арга хэмжээ авахаас зайлсхийсэн тохиолдолд үндэслэлтэй тайлбар шаардлагатай юм.

Ерөнхийдөө аудитын үр дүнг дараах байдлаар тодорхойлов:

<sup>8</sup> Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ) – баримт бичгийн дугаар ОТ-10-PLN-0003 2013.01.09.

- IV ангилалд хамаарах зөрчил илрээгүй;
- III ангилалд хамаарах зөрчил илрээгүй;
- II ангилалд хамаарах хоёр зөрчил илэрсэн;
- I ангилалд хамаарах долоон зөрчил илэрсэн.

Дорх хүснэгтэд БОНХЗ 2013 оны 10-р сард уурхайд ирж аудит хийснээс хойш илэрсэн зөрчлүүдийн төлөвийг нэгтгэн харуулав.

**Хүснэгт 3-1: БОНХЗ-ийн илрүүлсэн зөрчлийн статус**

Даалгаврын д/д.	Уурхайд хийсэн аудит	Шинээр илрүүлсэн зөрчил	Хаагдсан зөрчил	Хаагдаагүй зөрчил
M1	2013 оны 10-р сар	26	хамаарахгүй	хамаарахгүй
M2	2014 оны 4-р сар	11	8	29
M3	Баримт бичгийн аудит 2014 оны 8-р сар	2	3	28
M4	2014 оны 11-р сар	7	10	25
M5	Баримт бичгийн аудит 2015 оны 4-р сар	0	3	22
M6	2015 оны 9-р сар	4	6	20
M7	Баримт бичгийн аудит 2016 оны 4-р сар	1	9	12
M8	2016 оны 8-р сар	4	2	14
M9	2017 оны 5-р сар	1	6	9

## Хүснэгт 3-2: Зөрчлийн хүснэгт

Үүрэг / асуудлын д/д	Уурхайн аудит	Хаасан огноо	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
<b>Байгаль орчин – Ус, хаягдал усны менежмент</b>							
M1.5	13 оны 10-р сар 14 оны 4-р сар 14-оны 8-р сар- баримт бичгийн аудит 14 оны 11-р сар 15 оны 4-р сар-баримт бичгийн аудит 15 оны 9-р сар 16 оны 4-р сар-баримт бичгийн аудит 16 оны 8-р	2017 оны 5-р сар	Гидрогеологийн нэгжтэй гидравлик холбоотой тохиолдолд нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах шаардлагатай. Эдгээр бууруулах арга хэмжээг бүх цэгт хараахан хэрэгжүүлж амжаагүй байна. Оюу толгой эдгээр гидравлик холбоотой цооногийг ашиглахгүй орхих эсвэл үр ашигтайгаар ашиглах чиглэлээр хүчин чармайлт гарган ажиллаж байна.	II	БОНХЗ - 2013 оны 4-р сарын аудит  Усны нөөцийн менежментийн төлөвлөгөө (WR04, 14)	Хаасан	5.1.2.8 хэсгийг үзнэ үү. Гүний хоолойн усны цооногийн/эх үүсвэрийн талбай дахь хоорондоо гидравлик холбоотой болох нь тогтоогдсон үлдсэн зургаан цооногийг лацдах, актлах ажлыг амжилттай хэрэгжүүлсэн. ОТ Ханбогдын засаг даргын ашиглалтаас гаргахыг зөвшөөрсөн захирамжийг үзүүлсэн. Ашиглалтаас гаргах ажлыг Сав газрын захиргаа, ГТЗ, орон нутгийн иргэдийн төлөөлөлтэй хамтран гүйцэтгэсэн. Одоо гидравлик холбоотой есөн цооногийг бүгдийг нь лацдаж, ашиглахаа больсон.

Үүрэг / асуудлын д/д.	Уурхайн аудит	Хаасан огноо	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
	сар						
M2.3	14 оны 4-р сар 14-оны 8-р сар-баримт бичгийн аудит 14 оны 11-р сар 15 оны 9-р сар 16 оны 4-р сар- баримт бичгийн аудит 16 оны 8-р сар		УХШТ-нд тусгасан нэмэлт хяналтын цооногуудыг өрөмдөж тоноглох ажлыг хараахан хийгээгүй байна.	I	УХШТ, 3.2.6, 3.3.5 хэсэг  Усны нөөцийн менежментийн төлөвлөгөө (WR14, WRm06)	нээлттэй	5.1.2.9 хэсгийг үзнэ үү. УХШТ-нд зааснаар нэмэлт хяналтын цооногуудыг өрөмдөж тоноглох ажлыг бүрэн хийж дуусаагүй байна. 2016 оны хээрийн ажлын улиралд нийт 200 цооног нэмж гаргасан ба өмнө нь цөөн тооны хяналтын цэгтэй байсан ХХБ-ийн зүүн өмнөд хэсэгт 11 фезометр нэмж суурилүүлсан. 2017 оны талбайн ажлын үеэр Гүний хоолойн бүсэд нэмэлт хяналтын цооног гаргах болно. (гурван газарт есөн цэг гаргана.). ОТ ойрын хугацаанд нэмэлт хяналтын цэг байгуулах төлөвлөгөө батлагдсан байгаа тул энэ зөрчлийн ангиллыг II байсныг I болгож буурууллаа.
<b>Байгаль орчин – Эрдэс бус хаягдлын менежмент</b>							
M8.1	16 оны 8-р сар	2017 оны 5-р сар	Дотоодын дахин боловсруулах үйлдвэрүүдтэй байгуулсан бүх гэрээний хугацаа 2015 оны 9-р сард дууссан. Эдгээр гэрээг шинэчлэх хугацаа хараахан тодорхой болоогүй	I	Эрдсийн бус хаягдлын менежментийн төлөвлөгөө (WM01, WM05)	Хаасан	5.3.2. хэсгийг үзнэ үү. Хуванцар, хаягдал металл, машины баттерей, хаягдал тос, гал тогооны тос зэрэг тодорхой ангиллын хаягдлуудыг дахин боловсруулах компани, дотоодын үйлдвэрүүдтэй гэрээ байгуулснаар хог хаягдлыг уурхайгаас үе шаттайгаар гаргаж, Төслийн зөвшөөрсөн байгууламжид хадгалж

Үүрэг / асуудлын д/д.	Уурхайн аудит	Хаасан огноо	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
			байна. Энэ хооронд хуванцар сав, хаягдал төмөр зэрэг дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг Дахин боловсруулах хаягдал түр хадгалах байгууламж, шинээр байгуулсан Хаягдлын менежментийн төвүүдэд хадгалж байна.				байна. Одоо төслийн үйл ажиллагаа Хаягдлын менежментийн төлөвлөгөөний зарчим, стратеги болон Зээлдүүлэгч нарын шаардлага, олон улсын тэргүүн туршлагад нийцэж байна. Иймд энэ зөрчлийг хаасан.
<b>Байгаль орчин – Агаарын чанар</b>							
M1.11	13 оны 10-р сар 14 оны 4-р сар 14-оны 8-р сар- баримт бичгийн 14 оны 11-р сар 15 оны 4-р сар-баримт бичгийн 15 оны 9-р сар 16 оны 4-р		Том ширхэгтэй хүдрийн овоолгоос их хэмжээний тоос (тоосонцор) ялгардаг. Хөөсөөр тоос дарах систем суурилуулсан бөгөөд ажиллуулж байгаа үед ерөнхийдөө сайн үр дүнтэй байгаа. Орчны агаарын чанарт хяналт шинжилгээ хийх илүү дээр арга хэрэглэснээр эдгээр арга хэмжээний үр дүнг илүү баримттай тайлбарлах боломжтой болно.	I	Агаарт ялгарах хийн хаягдлын менежментийн төлөвлөгөө (AQ05)	Нээлттэй	5.5.2.1. хэсгийг үзнэ үү. Том ширхэгтэй хүдрийн овоолгын (ТШХО) байгууламж тоосжилт ихтэй байсаар ирсэн. Үйл ажиллагаанд хэд хэдэн удаа өөрчлөлт оруулж, хэд хэдэн төрлийн арга хэмжээ хэрэгжүүлснээр Хүдрийн овоолгын байгууламж орчмын агаарт тогтсон нийт тоосны нягтрал (TSP) нүдээр харахад багассан харагдаж байна. Тоосжилт буурсныг тоон үзүүлэлтээр нотлохын тулд орчны агаарын хяналт шинжилгээ хийх нь хүндрэлтэй байсан. Учир нь өдийг хүртэл дээжийг сард нэг удаа цуглуулж ирсэн ба салхины нөлөө, тухайн үеийн үйл ажиллагааны онцлогоос мөн хамааралтай байдаг. Орчны агаарын чанарыг тасралтгүй үнэлэх шинэ сүлжээг ашигласнаар тоосжилтыг бууруулах арга хэмжээний үр нөлөөг илүү сайн хянах, тухайн орчин дахь мэдрэг хүлээн авагчдад (голчлон баяжуулах үйлдвэрийн ажилтнууд, Манлай кэмп) үзүүлж буй үр нөлөөг хянах боломжтой болно. ТШХО-ын

Үүрэг / асуудлын д/д.	Уурхайн аудит	Хаасан огноо	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
	сар- баримт бичгийн 16 оны 8-р сар 17 оны 5-р сар						тоосжилтыг багасгах чухал арга хэмжээ хэрэгжүүлсэн. Орчны агаарын чанарын хяналт шинжилгээний дүнгээр баяжуулах үйлдвэр, манлай кэмп дэх ажиллах хүч хангалттай хэмжээнд хамгаалагдаж байгаа нь батлагдсан тохиолдолд энэ зөрчлийг хаана. М1.12-т дурдсаны дагуу Орчны агаарын чанарын хяналт шинжилгээг харьцангуй сайжруулсан байдлаар удахгүй хэрэгжүүлж эхэлнэ. Энэ мэдээний дүн, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилт зэргээс хамааран энэ зөрчлийг хаана. ОТ энэ зөрчлийг арилгах, орчны агаарын чанарын хяналт шинжилгээний сүлжээ суурилуулах тодорхой төлөвлөгөө ойрын хугацаанд хэрэгжүүлэхээр гаргасан тулд энэ зөрчлийг (ангилал 2 байсныг) 1-р ангиллын зөрчил болгож буурууллаа.
М1.12	13 оны 10-р сар 14 оны 4-р сар 14-оны 8-р сар-баримт бичгийн 14 оны 11-р сар 15 оны 4-р		Одоо ашиглаж байгаа орчны агаарын хяналт шинжилгээний сүлжээ учир дутагдалтай байна. Орчны агаарын чанарыг Төслийн шалгуур үзүүлэлттэй харьцуулан хянахын тулд нэмэлт тоног төхөөрөмж суурилуулах шаардлагатай талаар АЧМТ-нд дурджээ.	I	Агаарт ялгарах хийн хаягдлын менежментийн төлөвлөгөө - (ГҮ02 Агаарын чанарын хяналт шинжилгээний төлөвлөгөө- 2.5, 4.1 хэсэг Хавсралт, В)	Нээлттэй	5.5.2.1. хэсгийг үзнэ үү. Өмнөх аудитын тайлангуудад тэмдэглэсэнчлэн, шинэчилсэн АЧХШТ-нд заасан үүрэг амлалтаа биелүүлж, орчны агаарын чанарыг Төслийн шалгуур үзүүлэлттэй харьцуулан хянахын тулд орчны агаарын чанарын хяналтын сүлжээг сайжруулах шаардлагатай байна. 2016 оны 4-р улиралд шаардлагатай тоног төхөөрөмжийг уурхайд авчирсан. Үүнээс хойш тоног төхөөрөмж, тэвшийг ажиллуулах эрчим хүчний хангамж суурилуулах зэрэг техникийн ажлуудыг хийж дууссан. Ашиглалтад оруулах, уурхайд сургалт хийх ажлуудыг 2017 оны 3-р улиралд төлөвлөсөн ба ингэснээр тоног төхөөрөмж ажиллаж

Үүрэг / асуудлын д/д.	Уурхайн аудит	Хаасан огноо	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
	сар 16 оны 4-р сар- баримт бичгийн 16 оны 8-р сар 17 оны 5-р сар						эхэлнэ. Агаарын чанарын хяналт шинжилгээний сүлжээ суурилуулах ажлыг ойрын хугацаанд хэрэгжүүлж дуусах баттай төлөвлөгөөтэй байгаа тул энэ зөрчлийг (2-р ангилал байсныг) 1-р ангиллын зөрчил болгож бууруулсан.
M1.13	13 оны 10-р сар 14 оны 4-р сар 14 оны 8-р сар-баримт бичгийн 14 оны 11-р сар 15 оны 4-р сар-баримт бичгийн 15 оны 9-р сар 16 оны 4-р сар-баримт		Дулааны төв станцын (ДТС) болон Ханбогдын нисэх онгоцны буудалд ашиглаж буй уурын зуухны утаанаас авсан дээж төслийн стандартыг хангаж чадахгүй байна.	II	Агаарт ялгарах хийн хаягдлын менежментийн төлөвлөгөө (AM03)  Агаарын чанарын хяналт-шинжилгээний төлөвлөгөө – Б Хавсралт)	Нээлттэй	5.5.2.2. хэсгийг үзнэ үү. ДТС-ын утааны чанарын үзүүлэлт Төслийн стандартад хүрсэн удаа үгүй бөгөөд энэ асуудал байнга тавигдсаар ирсэн. Станцын утаанд хяналт шинжилгээ хийсэн хөндлөнгийн байгууллагын дүгнэлтээр утаанаас дээж авахад хэрэглэж байгаа аргачлалд хэд хэдэн дутагдалтай тал байгааг илрүүлсэн. АЧХШТ-ний шаардлагын дагуу ДТС-ыг 130 мВт-д шилжүүлэх 2 дахь шатны өргөтгөлийн ажлын хүрээнд Утааны тогтмол хяналт шинжилгээний систем (УТХШС)-ийг үндсэн нэг янданд суурилуулна. Бүх бойлеруудад бүрэн засвар үйлчилгээ хийсэн, нийт 1,500 гаруй уутат шүүлтүүр сольсон зэрэг бусад сайжруулалтын ажлууд ДТС-д хийгдсэн байна.  ОТ ойрын хугацаанд одоогийн Төслийн стандарттай холбоотой Өөрчлөлтийн мэдэгдэл өгөхөөр төлөвлөж байгаагаас гадна энэ асуудал урт хугацаанд нэг түвшинд байгаа тул энэ зөрчлийг 2-р ангиллын зөрчилд хэвээр үлдээж байна. Өөрчлөлтийн



Үүрэг / асуудлын д/д.	Уурхайн аудит	Хаасан огноо	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
	бичгийн 16 оны 8-р сар 17 оны 5-р сар						мэдэгдэлд тохирох Төслийн стандартыг хангахад ашиглах боломжтой хамгийн сайн технологийг мөн дурдах юм.
M2.4	14 оны 4-р сар 14-оны 8-р сар- суурин аудит 14 оны 11-р сар 15 оны 4-р сар- суурин аудит 15 оны 9-р сар 16 оны 4-р сар-суурин аудит 16 оны 8-р сар 17 оны 5-р		Шатаах зуухны утаанаас авсан дээж төслийн стандартыг хангаж чадахгүй байна.	I	Агаарт ялгарах хийн хаягдлын менежментийн төлөвлөгөө (AM06)  Агаарын чанарын хяналт-шинжилгээний төлөвлөгөө – С Хавсралт)	Нээлттэй	5.5.2.2. хэсгийг үзнэ үү. Шатаах зуухны утааны чанарын үзүүлэлт Төслийн стандартад хүрэхгүй асуудал урт хугацаанд үргэлжилж байна. ОТ сард 100 кг орчим хэмжээтэй үлдвэрлэгддэг эмнэлгийн хог хаягдлыг шатаах автоклавтай нэгэн компанитай гэрээ байгуулсан. Тос арчсан даавуу зэрэг бусад аюул учруулж болзошгүй хог хаягдлыг хаягдлын менежментийн төвд тусгай шугам/дамжлага гарган зохицуулж болох юм.  Ойрын хугацаанд шатаах зуухыг ашиглалтаас гаргахаар төлөвлөж байгаа тул энэ зөрчлийг 1-р ангиллын зөрчил болгон бүүрууллаа. Аюул учруулж болзошгүй хог хаягдлыг зайлуулах, зохицуулахад боломжит бусад арга замыг (тостой даавуу, эмнэлгийн хаягдлыг автоклавт шатаах зэрэг) ашиглах юм. Жилийн эцэс гэхэд (a) шатаах зуухыг бүрэн ашиглалтаас гаргаж, дахин ашиглахаа болих; (b) автоклав бүрэн ашиглалтад орсон байна гэж тооцож байна.

Үүрэг / асуудлын д/д.	Уурхайн аудит	Хаасан огноо	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
	сар						
M7.1	16 оны 4-р сар- суурин аудит 16 оны 8-р сар	2017 оны 5-р сар	Хүлэмжийн хийн ялгарлын бүртгэлийг хянаж, олон улсын тайлагналын шаардлагад тавигддаг шилдэг туршлагатай нийцүүлэх (тухайлбал, Дэлхийн тогтвортой хөгжлийн бизнесийн зөвлөл).	I	Агаарт ялгарах хийн хаягдлын менежментийн төлөвлөгөө (AQ02, AQ07)	Хаасан	5.5.2.4. хэсгийг үзнэ үү. Хөндлөнгийн байгууллагаас Оюу толгойн Хүлэмжийн хийн ялгаруулалтад үнэлгээ хийсэн тайланг 2016 оны 2-р сард эцэслэсэн. Энэ тайланд ялгарлыг тооцоолох аргачлал нь Рио Тинтогийн бүртгэлийн аргачлалтай нийцэж буй эсэхийг шалгахыг зөвлөсөн. Үүнийг 2016 онд гаргасан Рио Тинтогийн хүлэмжийн хий, эрчим хүчний хэрэглээний журнал хөтлөх удирдамжтай тулгаж, баталгаажуулсан. Рио Тинтогийн хүлэмжийн хийн бүртгэл нь Дэлхийн тогтвортой хөгжлийн бизнесийн зөвлөл/Дэлхийн нөөцийн институтын Хүлэмжийн хийн протоколд тусгасан тодорхойлолтуудад үндэслэсэн байдаг.
<b>Байгаль орчин – Биологийн олон янз байдал, экологийн менежмент</b>							
M2.6	14 оны 4-р сар 14-оны 8-р сар- суурин аудит 14 оны 11-р сар 15 оны 4-р	17 оны 5-р сар	Биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээний чиглэлээр Оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө.	I	Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөө (B05) ЗБОЯБУАТ ID 24, (БОЯБМТ Хавсралт С)	Хаасан	5.9.2.2. хэсгийг үзнэ үү. Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд ОТ нөлөөллийг бууруулах арга хэмжээ хэрэгжүүлэх, УАМТ-г бүс/тухайн нутаг орны түвшинд хэрэгжүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх, БОЯБУАТ17-ийн дагуу ОТ-н үйл ажиллагаагаа явуулахдаа талуудын оролцоог хангах ёстой гэсэн Зээлдүүлэгч нарын шаардлагыг хангах үндсийг бүрдүүлэх зорилгоор Оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулах үүрэгтэй. Экосистемийн ажлын групп нь биологийн олон янз байдлыг хадгалах, хамгаалах

Үүрэг / асуудлын д/д.	Уурхайн аудит	Хаасан огноо	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
	сар- суурин аудит 15 оны 9-р сар 16 оны 4-р сар-суурин аудит 16 оны 8-р сар						<p>чиглэлээр Оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулж, ОТ-н Оролцогч талуудтай хамтран ажиллах ерөнхий төлөвлөгөөнд хавсралтаар оруулсан бөгөөд уг төлөвлөгөөний төслийг 2016 оны 7-р сард зээлдүүлэгч нарт хянуулахаар өргөн барьсан.</p> <p>Өмнөх аудитаар ОТ дөрвөн дүйцүүлэн хамгаалах төслийн хүрээнд тодорхой оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөөг тухайн хийх ажлын сэдвээс хамааруулсан хамтран ажиллах төлөвлөгөөг илүү нарийвчлан боловсруулах шаардлагатай нь тодорхой болсон.</p> <p>Оролцогч талуудын хамтын ажиллагааны төлөвлөгөө (ОТХАТ) нь биологийн олон янзын байдлыг хамгаалах олон талуудын нэгдсэн жагсаалтаас гадна биологийн олон янз байдлыг хамгаалах шаардлагатай гэж үзэж буй газрууд, ОТ-н өгөх гол мессежүүдийг тодорхойлсон. Тус төлөвлөгөө хамтран ажиллах механизм, давтамж, түвшинг тодорхойлж, хариуцах эзнийг тодорхойлж өгсөн. ОТХАТ-ний хэрэгжилтийг сар бүр бүртгэж, биологийн олон янз байдлын чиглэлээр хамтран ажиллах зорилго, хүргэсэн гол мессеж, хийсэн уулзалтын үр дүнг тусгаж өгдөг. Хууль бус ан агнуур зэрэг биологийн олон янз байдлыг хамгаалахад хамтран ажиллах тодорхой үйл ажиллагааны төлөвлөгөөг тусгасан 2017 оны 5-р сарын бүртгэлтэй танилцсан. Нутгийн иргэдтэй хийсэн уулзалт болон мэдээллийн гарын авлагад хууль бусаар ургамал түүхийн эсрэг дүйцүүлэн хамгаалах</p>

Үүрэг / асуудлын д/д.	Уурхайн аудит	Хаасан огноо	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
							үйл ажиллагааг мөн хэлэлцсэн байна. “Г” Хавсралтын 1-р хүснэгтэд талуудтай хамтран ажиллах үйл ажиллагааг хэсэгчлэн төлөвлөсөн. БОНХЗ-ийн зүгээс оролцогч талуудын хамтын ажиллагааг эртнээс төлөвлөх, дүйцүүлэн хамгаалах төсөл тус бүрийн хувьд талуудтай хамтран ажиллах төлөвлөгөөний ерөнхий зорилго зорилтын биелэлтэд хяналт тавих, үнэлэх зэрэг хэд хэдэн зүйлсийг нэмж зөвлөсөн.  Энэ зөрчлийг одоо хаасанд тооцсон.
M4.5	14 оны 11-р сар 15 оны 4-р сар- суурин аудит 15 оны 9-р сар 16 оны 4-р сар-суурин аудит 16 оны 8-р сар	2017 оны 5-р сар	Нэн чухал экосистемийн үйлчилгээний хяналт шинжилгээ	I	БОЯБУАТ 17  БОНУАТ 7-р зүйл, Бэлчээр, амьжиргааг сайжруулах стратеги, НШАТ-ний Тэтгэмжийн матриц  БОЯБУАТ ID6	Хаасан	5.9.2.3. хэсгийг үзнэ үү. Экосистемийн үйлчилгээний группээр дамжуулан ОТ компани нэн чухал экосистемийн үйлчилгээнд чиглэсэн олон салбарын хяналт шинжилгээ, үнэлгээний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхээр болсон.  Гүйцэтгэлийн стандарт 6-ийн шаардлагыг хангахын тулд ОТ экосистемийн үйл ажиллагаа, түүнээс хүний хүртэх ашиг шим, үнэ цэнэ зэргийг авч үзэж, хяналт шинжилгээ хийхэд ашиглахаар төлөвлөж буй арга барилаа тодорхойлж өгөх ёстой. Хяналт шинжилгээний тогтолцооны хүрээнд нэн чухал экосистемийн үйлчилгээ цаг хугацааны явцад үнэ цэнээ алдах эсвэл үйл ажиллагаа муудсан тохиолдолд засч сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломжийг тусгаж өгөх ёстой.  Экосистемийн үйлчилгээний хяналт шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө (ЭҮХШҮТ)-г эхний байдлаар боловсруулж 2016 оны 6-р сард зээлдүүлэгчдэд

Үүрэг / асуудлын д/д.	Уурхайн аудит	Хаасан огноо	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
							<p>хянуулахаар өргөн барьсан. Зээлдүүлэгчдийн зүгээс чухал экосистемийн үйлчилгээнээс хүртэх үр ашигт сөрөг нөлөө үзүүлэхгүйг батлан харуулах боломжийг ОТ-д олгох үйлчилгээний хэрэглээ, үр ашгийг хэмжих үзүүлэлтүүдийг оруулж өгөх шаардлага тавьсан. ЭҮХШҮТ-г БОНХЗ-ийн 2016 оны 9-р сард хийсэн аудитаар өгсөн зөвлөмж, саналд үндэслэн шинэчлэн сайжруулсан байна. ОТ тус төлөвлөгөөг үндсээр нь сайжруулж, экосистемийн үйлчилгээний нийлүүлэлт, хэрэглээнд гарч байгаа өөрчлөлтийг хэмжих боломжтой болгосон байна.</p> <p>Зарим нэг орхигдсон зүйл байгаа ч гэлээ тус төлөвлөгөөг одоо хэрэгжүүлж эхлэхийг зөвлөж байна. ОТ-н төслийн ерөнхий зорилгыг биелүүлэхэд үг төлөвлөгөө хэр үр дүнтэйг дараагийн удаа уурхайд аудит хийхдээ дахин үнэлэх болно.</p> <p>Энэ аудитаар үг зөрчлийг хаав.</p>
M8.2	16 оны 8-р сар 2017 оны 5-р сар		Автозамын нөлөөллийг бууруулах стратеги	II	БОЯБУАТ (13)	Нээлттэй	<p>5.9.2.5. хэсгийг үзнэ үү. ОТ нь а) автозам хаах, замын хөдөлгөөний хязгаарлалт тогтоох б) бүсийн түвшний тогтвортой хөгжлийн асуудалтай холбоотой нөлөөллийг бууруулах тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх тал дээр холбогдох байгууллага, эрх бүхий этгээдүүдтэй албан ёсоор хамтран ажиллах с) ОТ-Гашуунсүхайд зам, бусад ОТ-н эзэмшлийн бус замууд дээр замын хөдөлгөөний хяналт тавих, тэдгээрийн ан амьтдад үзүүлэх нөлөөлөлд хяналт шинжилгээ хийх зэрэг асуудлуудыг тусгасан ОТ-Гашуунсүхайд замын нөлөөллийг бууруулах</p>

Үүрэг / асуудлын д/д.	Уурхайн аудит	Хаасан огноо	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
							<p>стратегийг боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг авсан. Зээлдүүлэгч нарт хянуулахаар 2016 оны 7-р сард илгээсэн стратегийн төсөлд Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөний шаардлагуудыг бүрэн хамруулаагүй байсан. Ялангуяа тус стратегид нөлөөллийг бууруулах боломжит хувилбаруудыг тусгаагүйн дээр замын хөдөлгөөнд хяналт тавих тодорхой аргачлалыг зааж өгөөгүй, ан амьтдад үзүүлэх нөлөөлөл, амьтдын үзүүлэх хариу үйлдлийг хэрхэн тайлбарлахыг (жишээлбэл загварчлал ашиглан эсвэл бусад аргаар тайлбарлах гэх мэт) тодорхойлж өгөөгүй.</p> <p>БОЯБУАТ-тэй холбоотойгоор ОТ болон зээлдүүлэгч нар замын нөлөөллийг бууруулах стратегийг үнэлэх хөндлөнгийн шинжээчдийн зөвлөл байгуулахаар тохиролцсон. Хөндлөнгийн шинжээчдийн зөвлөл үнэлгээ хийж дууссан ба тайлан эхний байдлаар гарч, одоо хянах шатандаа явж байна.</p> <p>Тиймээс, ОТ замын нөлөөллийг бууруулах стратеги тохиромжтой эсэх тал дээр одоогоор үүнээс илүү зүйл хэлэх боломжгүй байна. Иймд энэ зөрчил хөндлөнгийн шинжээчдийн зөвлөлийн тайлан эцэслэн гарч, ОТ/зээлдүүлэгч нар цаашид хийх ажлаа харилцан тохиролцох (БОЯБУАТ-ний дагуу) хүртэл нээлттэй хэвээр үлдэж байна.</p>
M8.3	16 оны 8-р сар		Ургамлын хяналт-шинжилгээний талбай байгуулж, тоосжилтоос бэлчээрт үзүүлж болзошгүй	I	Биологийн олон янз байдлын	Нээлттэй	5.9.2.6 хэсгийг үзнэ үү. Төслийн хувьд бэлчээрийн мал аж ахуйг экосистемийн чухал үйлчилгээ гэж үздэг бөгөөд барилгын үе шатанд тоосжилтын түвшин

Үүрэг / асуудлын д/д.	Уурхайн аудит	Хаасан огноо	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
	2017 оны 5-р сар		нөлөөлөлд хяналт шинжилгээ хийх		менежментийн төлөвлөгөө B15		<p>нэмэгдсэнээс ургамал ургалтыг дарангуйлж байгаа тухай санал гомдлын мөрөөр ОТ (Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд) тоосжилтоос бэлчээрт үзүүлэх болзошгүй нөлөөллийг хянах зорилгоор хяналт-шинжилгээний талбай байгуулах арга хэмжээ авсан. ОТ-н үйл ажиллагаанаас үүсч байгаа тоосжилт бэлчээрийн ургамал ургалтад нөлөөлөх магадлал байхгүй ч гэсэн үүнийг нотлох мэдээ баримт байхгүй учир цаашид үүнтэй холбоотой гарах санал гомдолд хариу өгөх үндэслэл байхгүй байгаа юм. ОТ ерөнхийдөө энэ асуудлын учрыг тайлж, тоосжилтын хяналт үнэлгээ хийх хэрэгцээг шаардлагыг тогтоох үнэлгээ хийх шаардлагатай. ОТ-н ургамлын хяналт шинжилгээний 32 талбайд хяналт шинжилгээ хийхэд сүүлийн хоёр жилд ямар нэгэн хүн хүүч, нөөц хуваарилаагүй. Энэ ажлыг гүйцэтгэх байгууллага (Экосистемийн хамгааллын үндэсний нийгэмлэг) сонгон шалгаруулсан ба энэ ажил хийгдэж байна.</p> <p>Өмнөх аудитаар байсан энэхүү зөрчлийг хаах ямар нэгэн баталгаа, нотолгоо байхгүй тул зөрчлийг хэвээр үлдээв. ОТ тоосжилт нь ялангуяа Ханбогдын зам дагуух ургамал ургалтад сөргөөр нөлөөлж буй эсэхэд хяналт шинжилгээ хийх нэмэлт гэрээт компани авах хүсэлтийг Хангамжийн хэлтэст тавьсан тухайгаа тайлагнасан. Энэ ажил хэрэгжиж эхлэхээр энэ зөрчлийг хаана.</p>
M9.1	2017 оны 5-р		Ховор ургамлын зүйл үржүүлэх	I	БОЯБХҮТ (Хавсралт 1)	Нээлттэ	5.9.2.4; 5.9.2.8. хэсгийг үзнэ үү. Ховор ургамлын

Үүрэг / асуудлын д/д.	Уурхайн аудит	Хаасан огноо	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
	сар				(OT-10-E14-PLN0003)  YAMT (OT-10-E14-PLN-0007) Хүснэгт 9  Газар хөндөх журам (OT-10-E14-PRC-0003-E)  Ховор ургамал хамгаалах журам (OT-10-E14-PRC-0007-E)	й	<p>зүйлийг хамгаалах, төсөлтэй холбоотой нөлөөллийг бууруулах арга хэмжээг Газар хөндөх, ховор ургамлын зүйлийг хамгаалах журамд оруулж өгсөн ба тэдгээр арга хэмжээг нөлөөлөл бууруулах арга хэмжээ хэрэгжүүлэх эрэмбийн дагуу хэрэгжүүлнэ. Ховор ургамлыг хамгаалах журамд ховор ургамалд сөрөг нөлөө үзүүлсэн эсвэл үзүүлж болзошгүй нөхцөлд OT ховор ургамлын зүйлийг ургуулах арга технологийг боловсруулах, ялангуяа ховор зүйлийн үржүүлгийн судалгаа хийх ёстой гэж заасан байдаг.</p> <p>Ханбогд сумын ховор ургамлын судалгааг 2016 онд хийсэн байдаг. OT уурхайн лицензийн талбай дахь ховор ургамлын байршлын зураг гаргасан ба уг мэдээллийг Газар хөндөх үйл ажиллагааны журмын дагуу тухайн төсөлд хяналт үнэлгээ хийхэд ашигладаг.</p> <p>Төслийн хяналт үнэлгээ хийхэд газар хөндөхийн өмнө кадастрын хэмжилт судалгаа хийж, ховор ургамал байгаа эсэхийг тодорхойлдог.</p> <p>Мод үржүүлэх төвд үржүүлгийн аргазүй түрших түршилтууд үргэлжилж байгаа ба ховор ургамлын тархац, амьдрах орчин нөхцөлийн талаар илүү ойлголт авах судалгааны ажил мөн үргэлжилж байна.</p> <p>Ажлын явц хэдий сайн байгаа ч зарим нэг ховор ургамлын зүйл хэдийнэ сөрөг нөлөөлөлд өртөж, өнөөг хүртэл үржүүлэг хийх баттай арга технологи боловсруулаагүй, судлаагүй байдалтай байна. Жишээ нь OT эерэг нөлөө ахиуц үзүүлэх ёстой Грубовын</p>



Үүрэг / асуудлын д/д.	Уурхайн аудит	Хаасан огноо	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
							<p>хөөндий (<i>Spongiocarpella grubovii</i>) нь уурхайн лицензийн талбайд цөөн байршилд байгаа нь нотлогдсон бөгөөд сүүлийн үеийн судалгаагаар тархац нь ганцхан уурхайн талбайн хойд хэсэгт маш бага тэлж байгаа нь тогтоогдсон. Энэ зүйл ургамлын тархац Монгол улсын хэмжээнд ямар байгаа талаарх мэдээллийг БОНХЗ-д өгөөгүй. ОТ-н хувьд энэ зүйлд эерэг нөлөөлөл ахиуц үзүүлэх үүрэг амлалтынхаа хүрээнд: а) Уурхайн лицензийн талбайд үлдсэн популяцийг нэмж сүйтгэх, хөндөхөөс бүрэн хамгаалах б) уурхайн лицензийн талбайгаас гадна өөр популяци байгаа эсэхийг судлаж тогтоох с) ялангуяа уурхай талбай дахь энэ зүйлийн популяцид хэдийнэ сөрөг нөлөө үзүүлсэн тулд энэ зүйлийг үржүүлэх боломжтой эсэхийг баталгаажуулах.</p> <p>Потанины улаан тулам (<i>Incarvillea potaninii</i>.) зэрэг зарим зорилтот зүйлийг олж тогтоох судалгааг хийх хэрэгтэй. Ингэхдээ жилийн тохиромжтой үеийг (ө/х ургамал цэцэглэх үед) сонгох хэрэгтэй ба уурхайд ажиллах биологийн олон янз байдлын багийн ажилтнуудын тоо цөөрсөн, уурхайн ажлын төлөвлөгөөнд өөрчлөлт орж байгаа зэргийг харгалзан үзэх нь чухал. Ховор ургамал тааралдсан газрын амьдрах орчны шинж байдлыг нарийн дэлгэрэнгүй дүрсэлсэн тодорхойлсоноор тэдгээр зүйлийн амьдрах орчин нөхцөлийн талаар илүү ойлголт мэдлэгтэй болох, улмаар үржүүлэг хийх арга технологи боловсруулахад тустай. ОТ <i>S.grubovii</i>. зэрэг нөлөөлөлд өртсөн ховор ургамал зэрэг бүх ховор</p>

Үүрэг / асуудлын д/д.	Уурхайн аудит	Хаасан огноо	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
							зүйлүүдийг үржүүлэх үржүүлгийн технологийг судлах судалгааны цогц хөтөлбөр хэрэгжүүлж буйгаа батлан харуулах шаардлагатай.
<b>Нийгэм –Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, амьжиргаа сайжруулах</b>							
M1.23	13 оны 10-р сар 14 оны 4-р сар 14 оны 8-р сар- суурин аудит 14 оны 11-р сар 15 оны 4-р сар-суурин аудит 15 оны 9-р сар 16 оны 4-р сар-суурин аудит 16 оны 8-р сар 17 оны 5-р		Нөлөөлөлд өртсөн малчдад чиглэсэн хөтөлбөрүүдэд Үр дүнгийн үнэлгээ хийх нь Нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөөнд заасан үүрэг бөгөөд Ханбогд сумын эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн болон бусад нөлөөлөлд өртсөн малчдыг хамарсан үр дүнгийн үнэлгээ хийх хугацаа болсон байна.	I	Нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөө (10.1, 10.2, 10.4 хэсэг)	Нээлттэй	6.3.2.2. хэсгийг үзнэ үү. Олон талт шинжээчдийн баг (ОТШБ) 2016 оны эхээр судалгаагаа эхлүүлсэн. ОТШБ-ийг сонгон шалгаруулж, судалгааны аргагүй, хуваарийг хэлэлцэж тогтсон бөгөөд үүний хүрээнд Ханбогд сумын 100 малчин өрхийг судалгаанд хамруулах, Сэврэй суманд хяналтын бүлэг байгуулах ажил орно. ОУСК/ ХДХЗО-ны газраас ГТЗ, ОТШБ, ХШЗ-тэй хамтран зөрчлийн менежментийн чиглэлээр сургалт зохион байгуулж, танилцах, мэдээлэл цуглуулах хамтарсан аялал хийсэн. Хээрийн судалгааны ажлыг 2016 оны 5-р сард хийсэн бөгөөд судалгаанд анх төлөвлөж байснаас 10-р илүү буюу 110 хүн хамрагдсан. Тайланг эхний байдлаар 2016 оны 9-р сарын дундуур Гурван талт зөвлөлд өргөн барина. Энэ ажил 2017 оны 1-р улиралд дууссан. Энэ чиглэлээр бодитой ажлууд хийж, ахиц гаргасан нь сайн хэрэг ч гэлээ үр дүнгийн үнэлгээ хийх ажлыг хийгээгүй хэвээр байна. Ханбогдын нөлөөлөлд өртсөн малчдын дунд үр дүнгийн үнэлгээ хийх ажлын явц ихээхэн хойшлогдсоор ирсэн бөгөөд дээрх судалгааны дүн цаг хугацаандаа гарах нь чухал. 2016 оны 8-р сард хийсэн аудитын үеэр БОНХЗ талууд амжилтад хүрсэнийг хэмжих үзүүлэлт буюу 'үр дүн'-д хүрсэн гэж үзэх үзүүлэлтийг харилцан

Үүрэг / асуудлын д/д.	Уурхайн аудит	Хаасан огноо	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
	сар						тохиролцсоноор яваандаа эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой зөрчлийг хаахад чухал үүрэг гүйцэтгэнэ гэж зөвлөсөн. ОТШБ-ийн судалгаа одоо дууссан ба энэ зөрчил нээлттэй хэвээр үлдсэн. 2017 оны 5-р сард Орон нутгийн харилцааны баг Үр дүнгийн үнэлгээ хийх байгууллага сонгон шалгаруулах зар гаргасан бөгөөд энэ ажил дээр нэмэлт, техникийн зөвөлгөө авах чиглэлээр Зээлдүүлэгчид, БОНХЗ-тэй хамтран ажилласан (энэ тайланг бэлтгэх үед үргэлжилж байсан). Үр дүнгийн үнэлгээг амжилттай хийж дуусах хүртэл энэ зөрчил нээлттэй байна.
<b>Нийгэм – Хүн амын шилжин ирэх хөдөлгөөний удирдлага</b>							
M8.4	2016 оны 8-р сар	2017 оны 5-р сар	Хүн амын шилжин ирэх хөдөлгөөнийг удирдах ОТ-н арга барилыг шинэчлэхэд ОТ, РТ эсвэл/мөн бусад компаниас зохих туршлагатай хүний нөөц хуваарилах Орон нутгийн болоод бүс нутгийн түвшинд одоогийн нөхцөл байдлыг бодитой тусгаж, Хүн амын шилжин ирэх хөдөлгөөний удирдлагын төлөвлөгөөг хянан засварлах ажлыг эцэслэх. Хүн амын шилжин ирэх хөдөлгөөнтэй холбоотой эрсдлийн менежмент нь Өмнийн говийн удирдах хороо зэрэг ОТ-н удирдлагын процесстой уялдсан	II	ОУСК ГС1(s19)	Хаасан	6.5.2.2. хэсгийг үзнэ үү. Өмнийн говийн удирдах хороо Өмнийн говийн удирдах хорооны ажлын удирдамж, чиглэлд хүн амын шилжин ирэх хөдөлгөөнийг удирдах асуудлыг (стратегийн зөвөлгөө өгөх, үйл ажиллагааны шийдвэр гаргах асуудал) хариуцах тухай тусгаагүй байна. Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын багийн хүн амын шилжин ирэх хөдөлгөөний менежмент хариуцахаар томилогдсон ажилтнууд нь энэ асуудлыг хариуцах хэмжээний туршлагаар дутмаг бөгөөд үүнд ахлах удирдлагын түвшний зохицуулалт хийх, мөн нийгмийн эрсдэл дагуулсан адармаатай асуудалд чиглэсэн, зохих менежмент хэрэгжүүлж байсан ажлын туршлагатай байх шаардлагатай. Хүн амын шилжин ирэх хөдөлгөөний менежментийн төлөвлөгөөг дахин авч хэлэлцэх ажлыг хийгдэж

Үүрэг / асуудлын д/д.	Уурхайн аудит	Хаасан огноо	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
			байх				байгаа ажилд оруулан тэмдэглэлээ. 2017 оны 5-р сард уурхайд аудит хийх үед Шилжин ирэх хөдөлгөөний менежментийн төлөвлөгөөг бүрэн эхээр нь дахин боловсруулсан байна. Шинэчилсэн менежментийн төлөвлөгөөнд Сумтай удирдлагын зохицуулалтууд хийж, хэрэгжилтийг хангах багц ажлуудыг тусгаж өгсөн байна.

